

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

2025 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛ



АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны
зах зээлийн
төлөв

8

ХАА–н гаралтай
бараа, түүхий
эдийн зах зээл

14

Биржийн
бус зах зээл

15

Уул уурхайн
бүтээгдэхүүний
зах зээл

17

Ашигт
ажиллагаа

19

Тогтвортой
байдал

24

Бодлого
зохицуулалт

25

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн
төлөв

28

Хүртээмжтэй
байдал

34

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

37

Ашигт
ажиллагаа

38

Тогтвортой
байдал

39

Бодлого
зохицуулалт

40

III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Зах зээлийн
төлөв

44

Хүртээмжтэй
байдал

49

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

52

Ашигт
ажиллагаа

55

Тогтвортой
байдал

57

Финтек ба
ногоон зээл

59

Бодлого
зохицуулалт

62

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Зах зээлийн
төлөв

66

Хүртээмжтэй
байдал

68

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

72

Ашигт
ажиллагаа

76

Тогтвортой
байдал

78

Бодлого
зохицуулалт

80

V. МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

Салбарын
төлөв

84

Хүртээмжтэй
байдал

88

Ашигт
ажиллагаа

90

Бодлого
зохицуулалт

91

VI. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Салбарын
төлөв

94

Хүртээмжтэй
байдал

95

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

97

Ашигт
ажиллагаа

99

Тогтвортой
байдал

100

VII. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

Салбарын
төлөв

104

Хүртээмжтэй
байдал

107

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

108

Ашигт
ажиллагаа

112

Бодлого
зохицуулалт

113

VIII. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын
төлөв

116

Хүртээмжтэй
байдал

117

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

118

Ашигт
ажиллагаа

119

Бодлого
зохицуулалт

120

IX. СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Сэндбоксад туршигдаж буй
бүтээгдэхүүнүүд

124

Бодлого
зохицуулалт

131

X. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Салбарын төлөв

134

Хүртээмжтэй
байдал

135

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

136

Ашигт
ажиллагаа







137

Бодлого
зохицуулалт

138

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	ҮЦК	Үнэт цаасны компани
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
АХБ	Азийн хөгжлийн банк	ХАА	Хөдөө аж ахуй
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт	ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ГҮТББ	Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага	ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч	ХК	Хувьцаат компани
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	ХХААДЗ	Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл
ЗМС	Зээлийн мэдээллийн сан	ТОС	Тогтвортой санхүүжилт
МИК	Монголын ипотекийн корпораци	АFI	Alliance for Financial Inclusion /Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	B2B	Business to business
МЗҮАЭ	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх	GIZ	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл	MSE	Mongolian stock exchange /Монголын хөрөнгийн бирж/
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо	OTC	Over the counter
СМА	Санхүүгийн мэдээллийн алба	P2P	Peer to peer
ТЗК	Тусгай зориулалтын компани	ROE	Return on equity
УБҮЦБ	Улаанбаатар үнэт цаасны бирж	ROA	Return on assets
УИХ	Улсын Их Хурал		
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал		
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал		

 <p>ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ</p>	<p>Зах зээлийн үнэлгээ 12,157.3 тэрбум төгрөг ЗЗҮ/ДНБ 15.2%</p>	<p>Даатгалын компаний тоо 20</p>	<p>Нийт хөрөнгө 703.7 тэрбум төгрөг</p>	<p>ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ </p>
<p>ТОП-20 индекс 49,246.17</p>	<p>Арилжааны дүн 503.9 тэрбум төгрөг</p>	<p>Даатгалын гэрээний тоо 2,154,246</p>	<p>Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж 250.6 тэрбум төгрөг</p>	
<p>ҮЦК-ийн тоо 53</p>	<p>Хөрвөх чадвар 0.9%</p>	<p>Даатгалын нөхөн төлбөр 88.2 тэрбум төгрөг</p>	<p>Нөөц сан 337.5 тэрбум төгрөг</p>	
<p>MSE A 17,825.99 MSE B 14,403.63</p>	<p>Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээ 1,397.6 тэрбум төгрөг</p>	<p>Цэвэр ашиг 30.1 тэрбум төгрөг</p>	<p>Давхар даатгалын хураамжийн зардал 50.2 тэрбум төгрөг</p>	<p>Нягтрал 142,736 төгрөг</p>
 <p>БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА</p>	<p>Тусгай зөвшөөрөлтэй 573 ББСБ</p>	<p>89.0% Зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй</p>	<p>Тусгай зөвшөөрөлтэй 177 ХЗХ</p>	<p>ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО </p>
<p>Нийт хөрөнгө 8.0 их наяд төгрөг</p>	<p>3.6 сая Харилцагч</p>	<p>Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2.4%</p>	<p>76,879 гишүүн</p>	<p>Нийт хадгаламж 259.4 тэрбум төгрөг</p>
<p>Нийт зээл 6.7 их наяд төгрөг</p>	<p>Нийт зээлдэгч 2.8 сая</p>	<p>Нийт хөрөнгө 376.9 тэрбум төгрөг</p>	<p>Цэвэр ашиг 8.1 тэрбум төгрөг</p>	<p>НИЙТ ЗЭЭЛ 294.8 тэрбум төгрөг</p>
<p>Зээлийн жигнэсэн дундаж хүү 3.6%</p>	<p>Нийт орлого 1,264.9 тэрбум төгрөг Хүүгийн орлого 1,129.2 тэрбум төгрөг</p>	<p>2.2% Зээлийн жигнэсэн дундаж хүү</p>	<p>1.4% Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү</p>	
 <p>ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ</p>	<p>ҮХЭХЗ-ын байгууллага 303</p>	<p>Хуулийн этгээд 56 Иргэн 492</p>	<p>ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИД </p>	
<p>Зуучлан худалдсан 1,398.3 тэрбум төгрөг</p>	<p>Зуучлан түрээслүүлсэн 125.6 тэрбум төгрөг</p>	<p>Үнэт металл худалдан авалт 123.9 тэрбум төгрөг</p>	<p>Үнэт металлын борлуулалт 140.6 тэрбум төгрөг</p>	



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

12,157.3
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо

2,608,449



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн

503.9
тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК-ийн хөрөнгө

450.8

тэрбум төгрөг

Улсын төсөвт
төвлөрүүлсэн
татвар, НДШ
(ҮЦК, ХОМК)

7.8

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Төвлөрөл

33Ү-ний **78.4** хувийг
Топ-10 ХК

Бодлого зохицуулалт



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Үнэт цаасны зах зээлд **НИЙТ 625** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа эрхэлж байна

Хувийн хөрөнгө оруулалтын сан (Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5.3 дахь заалт)

42

Мэргэжлийн холбоо, өөрийгөө зохицуулах байгууллага

1

Дэд бүтцийн байгууллага

Арилжаа эрхлэх байгууллага 3	Үнэт цаасны клирингийн байгууллага 2 /1 давхардсан/	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага 1
Үнэт цаасны төлбөрийн байгууллага 1 /давхардсан/	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж 1 /давхардсан/	ХАА–н бирж 1

Мэргэжлийн оролцогч

ҮЦК 53	ХОМК 35	Хамтын хөрөнгө оруулалтын сан 6
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч 14 /9 давхардсан/	ХАА–н түүхий эдийн брокер 9	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага 4

Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк

2 /1 давхардсан/

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч 68 /ТЗК/	Хөрөнгө итгэмжлэн удирдах 5	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч 2
---	---------------------------------------	--

Бүртгэлтэй этгээд

ҮЦЗЗ–д аудитын үйлчилгээ үзүүлэх 55 /7 давхардсан/	ҮЦЗЗ–д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 25 /давхардсан/	ҮЦЗЗ–д хуулийн үйлчилгээ үзүүлэх 44
--	---	---

ХК Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй – 164 ХК


311 Улаанбаатар үнэт цаасны биржид бүртгэлтэй – 2 ХК

*ҮЦК–д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамруулна.

Үнэт цаасны зах зээлийн арилжаа



- 2025 оны 2 дугаар улиралд 503.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 40.8 хувиар, 2021 оноос 22.1 хувиар буурсан үзүүлэлт юм.
- Нийт арилжааны 33.4 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)–ны, 22.1 хувийг хувьцааны, 17.5 хувийг компанийн бондын, 15.5 хувийг хөрөнгө оруулалтын сан (ХОС)–гийн нэгж эрхийн, 11.5 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)–ны арилжаа тус тус эзэлж байна.

Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/



Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Тайлант улиралд зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувиар өсөж 12,157.3 тэрбум төгрөгт хүрсэн бол хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 0.9 хувь байна.



ТОП 20 49,246.17

MSE A 17,825.99

MSE B 14,403.63

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,860.99 нэгжээр буюу 11.0 хувиар;
- MSE A индекс өмнөх оны мөн үеэс 602.26 нэгжээр буюу 3.5 хувиар;
- MSE B индекс өмнөх оны мөн үеэс 1,016.19 нэгжээр буюу 7.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХК–УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ



ТОП-20 индексийн багцыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал гэсэн шалгуур үзүүлэлтэд үндэслэн бүрдүүлдэг. Бүртгэлтэй компаниудын 22.8 хувийг, ТОП-20 индексийн багцын 65.2 хувийг банк санхүүгийн салбар бүрдүүлж байна.

ТОП-20 ИНДЕКСТ БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ-ЭЭР/





ҮЦТХТ-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

Монголын хөрөнгийн бирж (МХБ), Улаанбаатар үнэт цаасны бирж (УБҮЦБ) дээр идэвхтэй арилжаа явуулдаг 171 ХК-ийн хувьцааны төвлөрлийг 5-аас дээш болон түүнээс доош хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн тоогоор доор хүснэгтэд харуулав.



ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ


- Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-нд бүртгэлтэй 311 ХК-ийн өмчийн бүтцийг задлан харвал 89.4 хувь нь хувийн өмчит, 6.7 хувь нь төрийн өмчит, 3.9 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байна.

ҮНЭТ ЦААСНЫ ДАНСНЫ ТОО

- Шинээр 10,385 данс нээгдэж нийт дансны тоо 2,608,449-т хүрсэн бол 21,161 холболтын данс нээгдэж нийт 693,098-т хүрлээ.


НЭЭГДСЭН ДАНСНЫ ТОО

■ Холболтын данс ■ Шинэ данс



ДАНСНЫ ТОО
/ӨССӨН ДҮНГЭЭР/

2,608,449



АРИЛЖААНЫ БҮТЭЦ /үнийн дүнгээр/

- Арилжаанд оролцогчдын дийлэнх хувь буюу 58.0 хувийг дотоодын ААН-ийн хийсэн гүйлгээ эзэлж байгаа нь тэдний үнэт цаасны зах зээлийн идэвхжилт өндөр байгааг илтгэж байна. Харин дотоодын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 39.4 хувь, гадаадын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ 1.7 хувь, гадаадын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 0.9 хувийг тус тус эзэлж байна.

АРИЛЖААНД ОРОЛЦОГЧИЙН ТОО, ДАВТАМЖ /ӨССӨН ДҮНГЭЭР/


- Арилжаанд давтагдсан тоогоор нийт 66,792 иргэн, 1,064 ААН оролцож, 170,286 удаагийн арилжаа хийжээ. Хөрөнгө оруулагчдын 97.7 хувийг дотоодын иргэн, 1.4 хувийг дотоодын ААН, 0.8 хувийг гадаадын иргэн, 0.1 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.



	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо /давхардсан/	
ГАДААДЫН ААН	97	0.1%	535	0.3%
ГАДААДЫН ИРГЭН	522	0.8%	1,829	1.1%
ДОТООДЫН ААН	967	1.4%	6,612	3.9%
ДОТООДЫН ИРГЭН	66,270	97.7%	161,310	94.7%
НИЙТ	67,856	100.0%	170,286	100.0%


ҮЦК БАЙРШИЛ

- Улаанбаатар хотод 53 ҮЦК үйл ажиллагаа эрхэлж байна.



ҮЦК-ИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАЙРШИЛ

- ҮЦК-ийн 37 салбар, төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж буйгаас 36 нь орон нутагт, 1 нь Улаанбаатар хотод байршиж байна.




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Нийт хувьцааны арилжаа 111.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.0 хувиар, 2021 оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар тус тус буурчээ.

■ Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/



КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- Компанийн бондын арилжаа 88.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 6.4 дахин, 2021 оны мөн үетэй харьцуулахад 5.9 дахин буурчээ.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА

- ХОС-ийн арилжаа 77.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.0 дахин, 2021 мөн үетэй харьцуулахад 14.2 дахин өсжээ.

Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа /тэрбум төгрөг/



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/



ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

- ХБҮЦ-ны арилжаа 168.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин, 2021 оны мөн үетэй харьцуулахад 40.6 дахин өсжээ.

ШИНЭЭР ГАРГАСАН КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	ХБҮЦ-ны дүн /тэрбум төгрөг/
"Нэткапитал Эй Би Эс ТЭК" ХХК	2025.06.13	30.0

ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

- Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны арилжаа 58.1 тэрбум төгрөгт хүрсэн.

58.1



2025.II

ЗГДҮЦ
/тэрбум төгрөг/

ХӨДӨӨ, АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ




ХААБ-ээр нийт 5 төрлийн 204.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 453.2 тэрбум төгрөгөөр буюу 3.2 дахин буурсан.





ХАА-Н БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- 9 ХАА-ын брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 7 нь Улаанбаатар хотод, 2 нь орон нутагт байршиж байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улиралд биржийн бус зах зээлд нийт 63 үнэт цаас гаргагчийн, 69 өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс төгрөгөөр 709.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж бодитоор 538.8 тэрбум төгрөгийг, татан доллароор 30.0 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэж, 55.9 сая ам.долларыг тус тус татан төвлөрүүлжээ.



Биржийн бус зах зээлийн арилжаа 2021 оны 9 дүгээр сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаа эхэлснээс хойш 4,890.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг бүртгэж, 3,952.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Мөн доллароор 208.9 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэж, 173.4 сая ам.долларыг татан төвлөрүүлжээ. Нийт 1,426.9 тэрбум төгрөг, 15.3 сая ам.долларын өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, амжилттай эргэн төлсөн байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД


Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд бүртгэлтэй биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрхтэй бүртгэлтэй шууд оролцогч нийт 39 байна. Үүнээс авхардсан тоогоор андеррайтер 24, дилер 24, брокер 31, ХОС 5 компани байна. Харин шууд оролцогч нарт бүртгэлтэй шууд бус оролцогч хувь хүн 4,210, хуулийн этгээд 409 байна.



БОНДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ

Тайлант улиралд нийт бондын 45.4 хувийг санхүүгийн салбар, 26.9 хувийг барилга, 13.7 хувийг худалдаа үйлчилгээ, 10.6 хувийг уул уурхай, 1.8 хувийг үйлдвэрлэл, 1.2 хувийг боловсрол, эрүүл мэнд, эрүүл мэнд, 0.4 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.


БОНДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ



Санхүүгийн салбарын бондын 45.4 хувийг ББСБ, 48.3 хувийг барьцаалан зээлдүүлэх газар, 6.3 хувийг хөрөнгө оруулалтын компани тус тус эзэлж байна.


БОНДЫН ХУГАЦАА

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт бондын 58.3 хувийг 12 сарын хугацаатай, 26.4 хувийг 18 сарын хугацаатай, 12.5 хувийг 24 сарын хугацаатай, 2.8 хувийг 36 ба түүнээс дээш сарын хугацаатай бонд тус тус бүрдүүлээ.



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улирлын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 174 удаагийн арилжаагаар 5.3 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжлаа. Нийт 1,397.6 тэрбум төгрөгийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 4.4 дахин буурсан үзүүлэлт юм.




Нийт арилжааны 45.1 хувийг төмрийн хүдэр, баяжмалын арилжаа, 43.7 хувийг нүүрсний арилжаа, 10.0 хувийг зэсийн баяжмалын арилжаа, 1.2 хувийг хайлуур жоншны арилжаа тус тус эзэлж байна.

Бүтээгдэхүүний төрөл	Багцын тоо	Хэмжээ /мянган тонн/	Нийт үнийн дүн /тэрбум төгрөг/
Төмрийн хүдэр, баяжмал	902	2,960.4	630.5
Нүүрс	365	2,336.0	610.2
Зэсийн баяжмал	20	20.0	139.5
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	281	18.3	17.4
Нийт	1,568	5,334.7	1,397.6

ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА


Нийт 902 багц буюу 2,960.4 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 630.5 тэрбум төгрөгөөр арилжлаа. Нийт арилжааны 70.2 хувийг Fe – 58%–ийн төмрийн баяжмал, 20.4 хувийг Fe – 52%–ийн төмрийн баяжмал, 9.4 хувийг Fe – 65%–ийн төмрийн баяжмал тус тус эзэлж байна.



НҮҮРСНИЙ АРИЛЖАА

Нийт 365 багц буюу 2,336.0 мянган тонн нүүрсийг 610.2 тэрбум төгрөгөөр арилжлаа. Нийт арилжааны 33.1 хувийг 1/3 коксжих нүүрс, 24.7 хувийг дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс, 18.4 хувийг баяжуулсан коксжих нүүрс, 12.0 хувийг баяжуулсан сул коксжих нүүрс, 8.6 хувийг баяжуулсан коксжих чанаргүй нүүрс, 2.2 хувийг эрчим хүчний нүүрс, 1.0 хувийг чийг багатай хүрэн нүүрс тус тус эзэлж байна.


- 1/3 коксжих нүүрс
- Баяжуулсан коксжих нүүрс
- Баяжуулсан коксжих чанаргүй нүүрс
- Баяжуулсан сул коксжих нүүрс
- Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс
- Чийг багатай хүрэн нүүрс
- Эрчим хүчний нүүрс /Битумт, үл барьцалдах нүүрс/



ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Нийт 281 багц буюу 18.3 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 17.4 тэрбум төгрөгөөр арилжлаа. Нийт арилжааны 49.1 хувийг хайлуур жоншны баяжмал CaF2–97%, 41.0 хувийг хайлуур жоншны баяжмал CaF2–95%, 5.6 хувийг CaF2<42% хайлуур жоншны хүдэр, 4.3 хувийг CaF2<52% хайлуур жоншны хүдэр тус тус эзэлж байна.


- CaF2 <42% Хайлуур жоншны хүдэр
- CaF2 <52% Хайлуур жоншны хүдэр
- CaF2 97% Хайлуур жоншны баяжмал
- CaF2 95% Хайлуур жоншны баяжмал



ЗЭС БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Нийт 20 багц буюу 20.0 мянган тонн 22.35%–ийн зэсийн агуулгатай баяжмалыг 139.5 тэрбум төгрөгөөр арилжлаа.


АШИГТ АЖИЛЛАГАА




ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- Тайлант улиралд ҮЦК-уудын нийт хөрөнгө 450.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 дахин өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 2.2 тэрбум төгрөгөөр, зарлага 0.3 тэрбум төгрөгөөр буурч 12.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

ҮЦК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ



ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ



ҮЦК-УУДЫН УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, НДШ




- Үнэт цаасны компаниуд НДШ-д 2.7 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 2.1 тэрбум төгрөг, ХХОАТ-т 1.0 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт нийт 5.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.


МӨНГӨН ХӨРӨНГИЙН НОМИНАЛЬ ДАНСНЫ ТАЙЛАН

- Мөнгөн хөрөнгийн номиналь дансаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлж байгаа 21 компанид бүртгэлтэй 1,387,230 харилцагч байгаагаас тайлант улиралд 25,791 харилцагч номиналь дансаар дамжуулан үйлчилгээ авсан байна.


НОМИНАЛЬ ДАНСНЫ ХАРИЛЦАГЧИЙН ТОО



Тайлант улиралд 291.5 тэрбум төгрөгийн болон 54.0 сая ам.долларын гүйлгээ хийгдэж харилцагчдын мөнгөн хөрөнгийн номиналь дансны нийт үлдэгдэл 15.6 тэрбум төгрөг болон 2.0 сая ам.доллар байна.



ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



- ХОМК-уудын нийт хөрөнгө 146.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7 дахин буурсан үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 14.6 тэрбум төгрөгөөр, зарлага 22.7 тэрбум төгрөгөөр буурч 15.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.

ХОМК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ



ХОМК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ




ҮЦК-УУДЫН УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, НДШ



- ХОМК-ууд НДШ-д 0.4 тэрбум төгрөг, ХХОАТ-г 0.2 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 1.4 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт 2.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.


ХААБ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХААБ-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХААБ-уудын нийт хөрөнгө 5.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 2.5 тэрбум төгрөгөөр, зарлага 1.9 тэрбум төгрөгөөр буурч, 0.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

КАСТОДИАН БАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




КАСТОДИАН БАНКНЫ АШИГТ АЖИЛЛАГАА

- Кастодиан банкны нийт хөрөнгө 3,624.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 40.9 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.25 тэрбум төгрөгөөр өсөж, зарлага 0.13 тэрбум төгрөгөөр буурч, 0.39 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.


КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ

- Кастодиан банкны нийт харилцагчдын 91.5 хувийг дотоодын иргэн, 7.2 хувийг дотоодын ААН, 0.8 хувийг гадаадын иргэн, 0.5 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.

- Дотоодын иргэн
- Дотоодын ААН
- Гадаадын ААН
- Гадаадын иргэн




- Кастодиан банканд хадгалагдаж буй хөрөнгийг ангилан үзвэл 94.4 хувийг харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас, 2.2 хувийг мөнгөн хөрөнгө, 1.7 хувийг ХБҮЦ, 1.6 хувийг үүсмэл санхүүгийн хэрэгсэл үл хөдлөх эд хөрөнгө 0.1 хувийг тус тус эзэлж байна.



- Харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас
- Мөнгөн хөрөнгө
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл
- ХБҮЦ
- Үл хөдлөх эд хөрөнгө

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Зах зээлийн үнэлгээний 53.4 хувийг хамгийн өндөр үнэлгээтэй 5 компани, 78.4 хувийг 10 компани бүрдүүлж байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- ТОП–100 аж ахуйн нэгжийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан дэмжихтэй холбогдох зохицуулалт

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ТОП–100 аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог өсгөх, биржийн болон биржийн бус зах зээлд нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд үнэт цаас гарган санхүүжилт татан төвлөрүүлэх байдлыг нэмэгдүүлэх хүрээнд тэдгээрийн бонд гаргах ажиллагаанд тавигдах шалгуурыг багасгаж, хялбар шуурхай байдлаар бүртгэх зорилгоор “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”–уудад нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ оны 5 сард баталсан.

Тодруулбал, дээрх журмуудад ТОП–100 аж ахуйн нэгжээр шалгарсан компаниудад нийтэд санал болгон анх удаа хувьцаа /IPO/ гаргахад хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, нээлттэй болон хаалттай хүрээнд нэг жил хүртэлх хугацаатай 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бонд гаргахад аливаа барьцаа, батлан даалт, андеррайтертай гэрээ байгуулахыг шаардахгүй байх, мөн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгүүлэх тухай хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэх эсэх шийдвэрийг ажлын 10 хоногийн дотор гаргах зэрэг зохицуулалтуудыг тусгасан.

Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулснаар дотоодын томоохон компаниудад хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах зохицуулалтын таатай орчин бүрдэхийн зэрэгцээ үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ашигт ажиллагаа, нэр хүнд, засаглал нь сайжрах, улмаар гадаад, дотоодын зах зээлээс дахин санхүүжилт татахад давуу тал үүсэж, хөрөнгийн зах зээлийн хөгжил болон эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

- “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”–д нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 6 дугаар сарын 26–ны өдрийн хуралдаанаар “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”–д нийгмийн бонд болон тогтвортой байдлын бонд гаргахтай холбоотой зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг оруулж, Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо /International Capital Market Association/–оос гаргасан нийгмийн, тогтвортой байдлын бондын стандарт зарчмуудад

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

нийцүүлэн баталлаа.

Үүний үр дүнд Монгол Улсад ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн шинэ санхүүгийн бүтээгдэхүүний төрөл тоо нэмэгдэж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо нэмэгдэх зэргээр дотоодын бондын зах зээлийг хөгжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлэх юм.



ТОГТВОРТОЙ НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ

“Ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хоёрдугаар үе шатыг албан ёсоор эхлүүлэв.

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага, тогтвортой байдлыг бэхжүүлэх мөн байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг дэмжих замаар тогтвортой, ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-тай хамтын ажиллагааны санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Энэхүү санамж бичгийг үзэглэж “Ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хоёрдугаар үе шатыг албан ёсоор эхлүүлснээр дотоодын компаниудад ногоон бондоос гадна усны экосистем, био олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, гол мөрөн, усны ай савыг хамгаалах, нөхөн сэргээх бонд, байгаль орчин болон нийгэмд чиглэсэн тогтвортой хөгжлийг дэмжих бонд мөн тогтвортой хөгжлийн тодорхой зорилгод чиглэсэн хүрэх үр дүн тодорхой бонд, зорилгоо биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд бондын хүүгээ нэмэх, нэмэлт төлбөр өгөх зэргээр санхүүгийн хариуцлага хүлээдэг бонд зэрэг тогтвортой санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ. Ингэснээр байгаль орчинд ээлтэй санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж хөрөнгө оруулалт татах таатай нөхцөлийг бүрдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг нь төрөлжүүлэх боломж бүрдэж байна. Тодруулбал, олон улсын стандартад нийцсэн, илүү уян хатан, байгаль орчинд ээлтэй санхүүгийн тогтолцоог хөгжүүлж, манай улсын санхүүгийн салбарын хөгжилд бодит хувь нэмэр оруулах эхлэл тавигдаж байна.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Солонгос–Монголын санхүүгийн хамтын ажиллагааны форум” зохион байгуулагдлаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Солонгосын Санхүүгийн үйлчилгээний хороо (KFSC), Солонгосын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны зөвлөл (CIFC)-тэй хамтран “Солонгос–Монголын санхүүгийн хамтын ажиллагааны форум”-ыг 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Форумын үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага, сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн бодлогын гол арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар холбогдох талуудтай санал солилцов. Тус форум нь Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойтой давхцаж буйгаараа онцлог болсон бөгөөд хоёр улсын санхүү, хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох, шинэ боломжуудыг тодорхойлох чухал алхам боллоо.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө
703.7 тэрбум төгрөг
Хөрөнгийн өсөлт **14.1%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал
***142,736** төгрөг

*Монгол Улсын 2024 оны нийт хүн амын урьдчилсан тооцоог УСХ-ноос эрхлэн гаргасан. Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцооны тайлангаас нягтлан үзэж "А" хувилбараар гаргасан хүн амыг сонгож нягтралыг гаргасан болно.



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын
болон давхар даатгалын
нийт хураамж

81.3 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

30.1
тэрбум төгрөг

Улсын төсөвт
төвлөрүүлсэн
татвар, НДШ **9.5**
тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Давхар даатгалын
хураамжийн нийт
хураамжийн
орлогод эзлэх хувь

24.5%



Бодлого зохицуулалт



ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ


ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

2025 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр нийт 354 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 1,093 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна.



ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

- Гүнзгийрэлт 0.57 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.03 пунктээр, 2021 оны мөн үетэй харьцуулахад 0.01 пунктээр тус тус буурсан байна.



ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

Нийт 923,010 даатгалын гэрээний 749,116 буюу 81.2 хувийг хувь хүнтэй, 173,894 буюу 18.8 хувийг хуулийн этгээдтэй байгуулсан байна.

ХУВЬ ХҮН **749,116**

ХУУЛИЙН
ЭТГЭЭД **173,894**


Хувь хүнтэй байгуулсан гэрээний хүйсийн харьцаа /хувиар/



Хувь хүнтэй байгуулсан даатгалын гэрээг хүйсээр ангилж харвал 86.5 хувь нь эрэгтэй, 13.5 хувь эмэгтэй байна.


ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Нийт хөрөнгийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.1 хувиар өсөж 703.7 тэрбум төгрөгт хүрсэн бол 2021 оны мөн үетэй харьцуулахад 64.1 хувиар өсжээ.
- Erdийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар өсөж 614.6 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 87.3 хувийг эзэлж байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 хувиар өсөж 19.8 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувиар буурч 69.3 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 9.9 хувийг эзэлж байна.




ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БҮТЭЦ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 426.8 тэрбум төгрөг буюу 60.7 хувийг хөрөнгө оруулалт, 187.4 тэрбум төгрөг буюу 26.6 хувийг бусад хөрөнгө, 59.1 тэрбум төгрөг буюу 8.4 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 30.5 тэрбум төгрөг буюу 4.3 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө тус тус бүрдүүлж байна.



Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 4 даатгалын, 6–9 хувийг 4 даатгалын, 3–6 хувийг 4 даатгалын, 3 хувиас доош хувийг 8 даатгалын компани бүрдүүлж байна.

Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь




ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Хөрөнгийн өсөлтөөр нь бүлэглэвэл 30 хувиас дээш өсөлттэй 4, 20–30 хувийн өсөлттэй 1, 10–20 хувийн өсөлттэй 5, 10 хувиас доош өсөлттэй 3, хөрөнгийн хэмжээ буурсан 6 даатгалын компани байна.

Агис менежмент даатгалын компани нь 2024 оны 4 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул хөрөнгийн өсөлтийг тооцоогүй болно.


2023.ИИ–2024.ИИ / 2024.ИИ–2025.ИИ



НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 245.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамж бүрдүүлснээс ердийн даатгалын компаниуд 242.3 тэрбум төгрөг буюу 98.7 хувь, урт хугацааны даатгалын компани 3.2 тэрбум төгрөг буюу 1.3 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын хураамжид 50.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээс 5.1 тэрбум төгрөг буюу 10.2 хувийг дотоодын давхар даатгагч бүрдүүлсэн.
- Нийт хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувиар 2021 оны мөн үетэй харьцуулахад 1.2 дахин өсжээ.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж



Ердийн даатгалын нийт хураамж

2024.II

2025.II

Хөрөнгийн даатгал



16.6% 13.5%

Авто тээврийн хэрэгслийн даатгал



28.2% 28.6%

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал



13.6% 13.0%

Гэнэтийн осол, эмчилгээний даатгал



16.1% 19.8%

Бусад ердийн даатгал



9.3% 11.4%

Хариуцлагын даатгал



10.1% 7.4%

Агаарын хөлгийн даатгал



2.6% 2.3%

Барилга угсралтын даатгал



2.7% 2.7%


Урт хугацааны даатгал



0.8% 1.3%

НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 88.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.0 хувиар 2021 оны мөн үетэй харьцуулахад 2.0 дахин өсжээ.
- Нийт нөхөн төлбөрийн зардлын 86.3 тэрбум төгрөг буюу 97.9 хувийг ердийн даатгалын компани эзэлж байна.
- Давхар даатгагчийн нөхөн төлбөрийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52.2 хувиар өсөж 12.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



2024.11

2025.11

Ердийн даатгалын нөхөн төлбөр

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал



31.8%

27.7%

Авто тээврийн хэрэгслийн даатгал



27.9%

25.3%

Гэнэтийн осол, эмчилгээний даатгал



17.2%

24.0%

Хөрөнгийн даатгал



9.0%

4.6%

Бусад ердийн даатгал



11.2%

14.9%

Санхүүгийн даатгал



0.0%

0.0%

Урт хугацааны даатгал



1.4%

2.1%

Хариуцлагын даатгал



1.5%

1.3%

Барилга угсралтын даатгал





0.0%

0.1%

НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ 337.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.1 хувиар өсөж 300.2 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компаниудын нөөц сан 52.4 хувиар өсөж 5.5 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 6.5 хувиар өсөж 31.8 тэрбум төгрөгт хүрлээ.




* 2025.1 Давхар даатгалын орлогод тооцсон хураамжийн нөөцийг нэмэгдүүлж тооцоолсон.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Даатгалын салбарын өөрийн хөрөнгийг 2021 оны мөн үетэй харьцуулахад 43.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар өсөж 276.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Үүнээс 83.3 хувийг ердийн даатгалын компаниуд, 4.4 хувийг урт хугацааны даатгалын компаниуд 12.3 хувийг давхар даатгалын компаниудын өөрийн хөрөнгийн хэмжээ эзэлж байна.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ

Орон нутаг

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч бол даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Орон нутагт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлгээний нийт 687 төлөөлөгч, 434 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

ДААТГАЛЫН КОМПАНИ, ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН САЛБАР /БАЙРШЛААР/



БАРУУН БҮС

ДААТГАГЧ

43

ЗУУЧЛАГЧ

36

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

5

ХАНГАЙН БҮС

ДААТГАГЧ

53

ЗУУЧЛАГЧ

47

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

14

ТӨВИЙН БҮС

ДААТГАГЧ

72

ЗУУЧЛАГЧ

83

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

22

ЗҮҮН БҮС

ДААТГАГЧ

27

ЗУУЧЛАГЧ

25

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

7

ТӨЛӨӨЛӨГЧИД

113

231

240

103

САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ

Улаанбаатар хот

- Улаанбаатар хотод 302 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулсан ба үүнээс даатгалын компанийн 39, даатгалын зуучлагчийн 219, хохирол үнэлэгчийн 44 салбар байна. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.7 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.




- Улаанбаатар хотод нийт 400 төлөөлөгч үйл ажиллагаа явуулав.
- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 15 даатгалын компанийн төлөөлөгчийн газар байна. Үүнээс БНХАУ, БНСУ-д тус тус нэг байна.

	СОНГИНО ХАЙРХАН	ЧИНГЭЛТЭЙ	СҮХБААТАР	БАЯНЗҮРХ
ДААТГАГЧ	3	5	10	4
ЗУУЧЛАГЧ	18	37	47	40
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	10	4	7	10
	ХАН-УУЛ	БАЯНГОЛ	НАЛАЙХ	БАГАНУУР
ДААТГАГЧ	2	4	3	7
ЗУУЧЛАГЧ	38	29	6	4
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	5	7	0	1
	БАГАХАНГАЙ			
ДААТГАГЧ	1			
ЗУУЧЛАГЧ	0			
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	0			


АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9 хувиар өсөж 27.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт даатгалын хураамжийн орлогын 11.1 хувийг эзэлж байна.
- Олгосон нөхөн төлбөр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.9 хувийн өсөлттэй бөгөөд 24.4 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 27.7 хувийг эзэлж байна.



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

Даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 81.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үед 13.5 тэрбум төгрөг байснаас 22.0 хувиар өсөж 16.5 тэрбум төгрөгт хүрэв.




ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД

○ Даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 22,221 хохирлыг 41.8 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.3 хувиар өсөж 3.1 тэрбум төгрөгт хүрлээ.



ДААТГАЛЫН НЯГТРАЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцоолох боломжгүй.



- Даатгалын нягтрал 2024 онд 142,736 төгрөг болж 2023 онтой харьцуулахад 23.7 хувиар, 2020 онтой харьцуулахад 133.5 хувиар тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 23.6 хувиар өсөж 141,451 төгрөг бол урт хугацааны даатгалын хураамж 38.7 хувиар өсөж 1,285 төгрөгт хүрсэн байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



- Ердийн болон урт хугацааны даатгалын 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал” –аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.
- Давхардсан даатгалын бүтээгдэхүүний тоо өмнөх оны мөн үеэс 57 бүтээгдэхүүн, 2021 оны мөн үеэс 190 бүтээгдэхүүнээр нэмэгдэж 790 болсон байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар өсөж 30.1 тэрбум төгрөгт хүрсэн. Харин 2021 оны мөн үетэй харьцуулахад 76.2 хувиар өссөн байна.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг компаниар бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 8, 50 хувь хүртэлх өсөлттэй 5, 50–100 хувь хүртэлх өсөлттэй 1, 100 хувиас дээш өсөлттэй 5 компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

- Нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 пунктээр өсөж 4.4 хувьд хүрсэн бол өөрийн хөрөнгийн өгөөж 2.8 пунктээр өсөж 10.8 хувьд хүрэв.

5.2

тэрбум төгрөг

НДШ

3.4

тэрбум төгрөг

ААНОАТ

0.9

тэрбум төгрөг

ХХОАТ

- Даатгалын компаниуд 5.2 тэрбум төгрөгийг НДШ-д, 3.4 тэрбум төгрөгийг ААНОАТ-т, 0.9 тэрбум төгрөгийг ХХОАТ-т төлж нийт 9.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 50.2 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн 5.1 тэрбум төгрөгийг дотоодын давхар даатгагчдад, үлдсэн 45.1 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал даатгалын нийт хураамжийн 20.5 хувьтай тэнцэж байна.
- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.

20.5%

Давхар даатгалын хураамжийн нийт хураамжид эзлэх хувь

Давхар даатгалын хураамж




Жич: 1. Давхар даатгалын хураамжийг өссөн дүнгээр тооцсон.
2. Монголбанкны ам.долларын хаалтын ханшийн дунджаар тооцов.

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АНГИЛАЛ /ЭЗЛЭХ ХУВЬ/


- Хөрөнгийн зах зээл буюу үнэт цаас болон деривативт оруулсан хөрөнгө оруулалтын дүн 98.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт хөрөнгө оруулалтын 23.0 хувийг эзэлж байна. Харин банкны салбарт байршуулсан хөрөнгө оруулалт 327.1 тэрбум төгрөг буюу 76.6 хувьд хүрлээ.

- Хадгаламж, хадгаламжийн сертификат
- Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт
- Үнэт цаас
- Үнэт металл, дериватив



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ

Даатгалын компаниудын үнэт цаасны зах зээлд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, хадгаламж, хадгаламжийн сертификат буюу банкны салбарт оруулсан хөрөнгө оруулалт 4.6 хувиар буурсан байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах, УИХ–д өргөн мэдүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж байна. Даатгалын багц хуулийн төсөл батлагдсанаар даатгалын хамрагдалт нэмэгдэж, ДНБ–д эзлэх даатгалын хураамжийн орлогын хувь өсөх, дотоодын давхар даатгагчийн хүлээх эрсдэлийн хэмжээ нэмэгдэж, гадаад улс руу шилжүүлж буй давхар даатгалын хураамжийн нийт хураамжид эзлэх хувь буурах, даатгалын зах зээлийн бүтэц тэнцвэржих буюу урт хугацаа болон ердийн даатгалын харьцаа 40/60–д хүрэх, салбарт цахим технологи бүрэн нэвтэрснээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдэх, даатгуулагчийн сэтгэл ханамж дээшилж, даатгалд итгэх олон нийтийн итгэл нэмэгдэх зэрэг эерэг нөлөөг үзүүлнэ.
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 30–ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын төлөөлөл орж ажиллан, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд урт хугацааны даатгагч оролцох боломж, түүний зохицуулалтыг нарийвчлан сайжруулах хүрээнд холбогдох саналуудыг өгч ажиллаж байна.
- Улсын Их Хурлын даргын 2025 оны 1 дүгээр сарын 28–ны өдрийн 66 дугаар захирамжаар Хөдөө аж ахуйн даатгалын анхдагч хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэ хүрээнд тус ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож, холбогдох тайлбар, мэдээллээр ханган ажилласан. Хуулийн төслийн судалгаа хийх, санал боловсруулах хүрээнд даатгалын салбарын оролцогчдын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Сангийн яам (СЯ), Улсын Их Хурлын Тамгын газар (УИХТГ), Үндэсний давхар даатгал (ҮДД)–ын төлөөлөлтэй санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Хөдөө аж ахуйн салбар дахь эрсдэлийн удирдлага, хариуцлага, хяналтын тогтолцоог даатгалын салбарын оролцоотойгоор бүрдүүлж, үр дүнтэй шийдвэрлэх эрх зүйн үндэс тавигдах болно.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25–ны өдрийн 66 дугаар тогтоолоор ипотекийн даатгалын үйл ажиллагааны шинэчилсэн зохицуулалтыг баталж, 2025 оны 8 дугаар сарын 01–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан. Үүнтэй холбогдуулан урт хугацааны даатгалын компаниудын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг эрчимжүүлэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байна.
- Даатгагч, даатгалын зуучлагч болон хохирол үнэлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх тогтоолын төслүүдийг боловсруулж, төсөлд салбарын оролцогчид болон олон нийтээс санал авахаар Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудаст байршуулаад байна.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Мөнгөугаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний даатгалын салбарын дэд ажлын хэсгийн хүрээнд даатгалын байгууллагуудаас ирүүлсэн дата мэдээллийг хянах, нэгтгэх, шаардлагатай нэмэлт мэдээллийг авах зэрэг бэлтгэл ажлуудыг гүйцэтгэв.
- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлагаас зохион байгуулсан "Introduction to ORSA Requirements", "Risk-Based Capital (RBC) and Stress Testing", "AM Best BCM Building Blocks" сэдэвт сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцсон.
- 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын даатгалын зах зээлийн холбоо хамтран "Зах зээлийн эрүүл хөгжлийг дэмжих: Залилангаас сэргийлэх цогц тогтолцоо" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Хонконг, Сингапур дахь IBNR Management Consulting компанийн Ази тив хариуцсан захирал Рудольф Фрай сургалтыг удирдан явуулж, оролцогчдод залилангаас сэргийлэх аргачлал, салбарын оролцогчдын үүргийн талаар мэдээлэл хүргэсэн.
- Солонгос-Монголын санхүүгийн хамтын ажиллагааны форумын хүрээнд БНСУ-ын Амьдралын даатгалын холбооны төлөөлөлтэй хийх уулзалтыг зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцсон.
- Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуун болон Даатгалын газрын төлөөлөл БНСУ-ын Сөүлийн баталгааны даатгалын газрын удирдлагуудтай уулзлаа. Уулзалтаар хоёр орны баталгааны даатгалын зах зээлийн нөхцөл байдал, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, баталгаа гаргах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 199 дүгээр тушаалаар Даатгалын бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.
- 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зах зээлийн холбооны гишүүн компаниудад зориулан "Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ), тогтвортой байдлын тайлагнал" сэдэвт сургалтыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Сургалтаар даатгалын салбарын удирдах ажилтнуудад БОНЗ болон тогтвортой байдлын тайлагналын чиг хандлага, олон улсын стандарт, сайн туршлагын талаар мэдээлэл өгч, 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор уг тайланг гаргаж хэвших шаардлага, түүний ач холбогдлын талаар онцлон танилцуулсан.
- Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын салбарт үйл ажиллагаа явуулах эрх олгох нийт 5 удаагийн сургалтад даатгалын салбарын өнөөгийн байдал, олон улсын чиг хандлага, мөн хууль эрх зүйн зохицуулалт, холбогдох дүрэм журам, аргачлалын талаар хичээл зааж, хамтран ажилласан.
- Урт хугацааны даатгагчидтай хийсэн ипотекийн даатгалын шинэчилсэн зохицуулалт, ач холбогдлын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх болон даатгалын хураамжийг бууруулахтай холбогдох уулзалтуудад оролцсон. "Мандал лайф даатгал" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Жонн Спенс болон бусад албан тушаалтантай уулзалт зохион байгуулж, амьдралын даатгалын зах зээл, тус компанийн баримталж буй бодлого, Санхүүгийн зохицуулах хорооны хүргүүлэх санал хүсэлтийн талаар ярилцсан.
- Сингапур Улсад 2025 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан "20 дахь удаагийн Азийн Эрүүл мэнд ба Эрүүл мэндийн даатгалын бага хурал"-д Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцсон.
- СЭЗИС-аас зохион байгуулсан "Нээлттэй шинжлэх ухаан ба тогтвортой хөгжил", "Санхүүгийн зах зээл ба тогтвортой хөгжил" сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд даатгалын талаар илтгэл тавьж, олон нийтэд даатгалын талаар мэдээлэл өгсөн.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

8.0 их наяд
төгрөг

Хөрөнгийн өсөлт

38.7%



Санхүүгийн зах зээлийн төлөв

Харилцагч

3.6 сая

Дундаж зээлийн хэмжээ

2.4 сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Зээлийн ББСБ

89.0%

Зөвхөн гадаад валютын
арилжааны ББСБ

10.5%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

1,264.9

тэрбум төгрөг

Улсын төсөвт
төвлөрүүлсэн
татвар, НДШ

109.3

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс

17.0

Чанаргүй зээлийн нийт
зээлд эзлэх хувь

7.7%

Бодлого зохицуулалт



ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

2025 оны 2 дугаар улирлын байдлаар 573 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувиар өсжээ.





ББСБ-уудын 4.9 хувь нь гадаадын, 95.1 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



ББСБ-УУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 7,983.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2,226.8 тэрбум төгрөгөөр буюу 38.7 хувиар, 2021 оны мөн үеэс 3.5 дахин өсжээ.



ББСБ–уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/


САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,616.0	95.4%	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	664.2	8.3%	
Хөрөнгө оруулалт	97.0	1.2%	
Зээл /цэврээр/	6,588.3	82.5%	
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	58.7	0.7%	
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	4.8	0.1%	
Бусад санхүүгийн хөрөнгө	203.0	2.6%	
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	367.4	4.6%	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,983.4	100.0%	

- ББСБ–ын салбарын нийт хөрөнгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.7 хувиар буюу 2,226.8 тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд зээлийн 93.6 хувийн өсөлт нөлөөлөв.

ББСБ–уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,758.0	47.1%	
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,511.0	44.0%	
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,175.3	14.7%	
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,419.5	17.8%	
Бусад эх үүсвэр	673.0	8.4%	
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	3.5	0.1%	
Бусад санхүүгийн өр төлбөр	229.1	2.9%	
Хоёрдогч өглөг	10.6	0.1%	
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	–	0.0%	
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	247.0	3.1%	
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,225.3	52.9%	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,980.5	24.8%	
Нэмж төлөгдсөн капитал	102.8	1.3%	
Халаасны хувьцаа	2.6	0.1%	
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.5	0.3%	
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,010.7	25.2%	
Бусад өмч	111.4	1.4%	
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,983.4	100.0%	

- Салбарын эх үүсвэрийн бүтцийн 47.1 хувь нь өр төлбөр, 52.9 хувь нь өөрийн хөрөнгө болно.
- Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр 32.8 хувиар, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 62.8 хувиар, ББСБ–аас гаргасан өрийн бичиг 48.2 хувиар тус тус өссөн байна.




	ББСБ-ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
Топ 25 %	4	0.7%	1,991.2	24.9%	1,743.3	26.1%	2.2%	420,581	11.6%
Топ 50 %	14	2.4%	3,971.6	49.7%	3,432.4	51.4%	3.4%	1,614,373	44.7%
Топ 75 %	58	10.1%	5,982.1	74.9%	5,137.8	77.0%	5.4%	3,217,287	89.1%
САЛБАРЫН НИЙТ	573	100.0%	7,983.4	100.0%	6,674.9	100.0%	7.7%	3,611,895	100.0%

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ-уудын салбарын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 2.2, 3.4 болон 5.4 хувьтай байна. Өөрөөр хэлбэл салбарт эзлэх хувь өндөртэй ББСБ-уудын зээлийн чанар салбарын дундажтай харьцуулахад доогуур байна.

	ББСБ-ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	545	6,961.6	87.2%	5,832.6	87.4%	3,446,237	95.4%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	28	1,021.8	12.8%	842.3	12.6%	165,658	4.6%


Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын 42.9 хувь буюу 12 нь Япон, 25.0 хувь буюу 7 нь БНСУ, 7.1 хувь буюу 2 нь АНУ, 10.7 хувь буюу 3 нь БНХАУ үлдсэн нь Их Британи, Канад, Малайз, Сичелл зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна.



ББСБ-уудын нийт хөрөнгө Монгол Улсын ДНБ-ий 10.0 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байна.



Зээлийн хүү: ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өссөн байна.



НИЙТ ЗЭЭЛ

Салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 45.4 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр, 2021 оноос 4.2 дахин буюу 5.1 их наяд төгрөгөөр өсжээ.



ХЭВИЙН

87.3%

-3.5%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

5.0%

+2.0%



ЧАНАРГҮЙ

7.7%

+1.5%

7.4 их наяд төгрөг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | **6.5 их наяд төгрөг**

Бөөний болон жижиглэн худалдаа



7.0% | 6.4%

Барилга



2.6% | 2.5%

Тээвэр, агуулахын үйл ажиллагаа



2.1% | 2.3%

Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа



1.4% | 1.2%

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа



1.1% | 1.0%

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ



0.8% | 0.8%

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур



0.6% | 0.4%

Бусад



84.4% | 85.4%

ИРГЭН



89.4%

92.9%

94.0%

ХУУЛИЙН ЭТГЭЭД



10.6%

7.1%

6.0%

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

Нийт зээлийн үлдэгдлийн 89.4 хувь нь иргэнд, 10.6 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл эзэлж байна.




Олгосон зээл

Төлөгдсөн зээл

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ



Нийт олгосон зээлийн 65.3 хувь, төлөгдсөн зээлийн 69.6 хувийг хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлж байна.




ББСБ-ын салбарын олгосон зээлийн хамгийн их хувийг 1 сар хүртэлх болон 6-12 сарын хугацаатай олгосон зээл эзэлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Улсын хэмжээнд 573 ББСБ болон тэдгээрийн 561 (Австрали улсад 1 салбар) салбар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын байршлыг зураглалаар харуулбал дийлэнх буюу 83.4 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.






Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (АFI)-ийн улс орнуудад санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг тооцвол:

11 аймагт 3 буюу түүнээс дээш тооны ББСБ ажиллаж байгаа нь нийт ББСБ-ын 52.4 хувийг эзэлж байна.

1,000 хүн аж ахуй нэгжид ногдох



100,000 хүн амд ногдох



Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 478 ББСБ-ын 33.0 хувь нь Сүхбаатар, 27.2 хувь нь Чингэлтэй, 13.6 хувь нь Баянгол, 12.6 хувь нь Хан-Уул, 11.7 хувь нь Баянзүрх, 1.7 хувь нь Сонгинохайрхан, 0.2 хувь нь Багануур дүүрэгт байршилтай байна.

ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 57.2 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 10.5 ББСБ ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 31.2, 9.6 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Төвийн бүс 100,000 иргэнд 43.1 ББСБ, зүүн бүс 1,000 аж ахуй нэгжид 12.6 ББСБ ногдох хүртээмжээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотын хувьд 100,000 иргэнд 84.7 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 10.8 ББСБ ногдож байгаа нь орон нутгаас хүртээмж сайтай байна.

Улсын хэмжээнд
100,000 хүнд

57
ББСБ

1,000 аж
ахуйн нэгжид


11
ББСБ




ДУНДАЖ ЗЭЭЛ

- Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 2.4 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 1.7 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 2.4 сая төгрөг байна.
- Уг үзүүлэлт өмнөх оны мөн үед улсын хэмжээнд 2.5 сая төгрөг байсан нь тайлант улирлаас 2.7 хувиар буурсан.


ББСБ-ын харилцагчид



ББСБ-ын зээлдэгчид /насны бүлгээр/



ББСБ-ын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



ББСБ-ын ажилчид



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



ББСБ-ЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

ББСБ–уудын нийт орлого 1,264.9 тэрбум төгрөгт хүрэв.

Үүнээс 97.8 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байгаагаас 89.3 хувь буюу 1,129.2 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 8.5 хувь буюу 107.1 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.




ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 68.8 хувь буюу 73.8 тэрбум төгрөг санхүүгийн үйлчилгээний орлого, 12.9 хувь буюу 13.8 тэрбум төгрөг арилжааны орлого, 13.6 хувь буюу 14.5 тэрбум төгрөг гадаад валютын ханш болон үнэлгээний тэгшигтгэлийн орлого, 4.7 хувь буюу 5.0 тэрбум төгрөг бусад хүүгийн бус орлого бүрдүүлж байна.


БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

- ББСБ–уудын зардал 807.2 тэрбум төгрөгт хүрсэн. Уг зардлын 69.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал буюу хүүгийн болон хүүгийн бус зардал эзэлж байгаа бол 32.9 хувь буюу 265.1 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал, 36.9 хувь нь буюу 298.0 тэрбум төгрөгийг хүүгийн зардал бүрдүүлж байна.





Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлтэй холбоотой гарах зардал буюу болзошгүй эрсдэлийн зардал 147.6 тэрбум төгрөг ба үүний 81.5 хувийг зээлийн эрсдэлийн зардал, 11.9 хувийг авлагын эрсдэлийн сангийн зардал, 3.0 хувийг факторингийн тооцооны авлагын эрсдэлийн сангийн зардал, 1.9 хувийг банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, 1.2 хувийг бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, 0.3 хувийг өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, 0.2 хувийг өмчлөх бусад санхүүгийн бус хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал тус тус эзэлж байна.

- Факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 4 банк, 58 ББСБ байна. ББСБ-ууд факторингийн тооцооны авлагын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин өсжээ.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага
/тэрбум төгрөг/

- Салбарын хэмжээнд 92 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байгаа ба тэдгээрийн татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.8 хувиар өссөн байна.

Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр
/тэрбум төгрөг/Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого
/сая төгрөг/


- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлж буй 55 ББСБ-аас 13 ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс 5,212.2 сая төгрөгийн орлого олсон нь өмнөх оны мөн үеэс 2,185.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ

ББСБ-ууд тайлант улиралд 1,842.1 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 1,824.1 тэрбум төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 51.6 хувийг, худалдсан валютын 50.9 хувийг АНУ-ын доллар бүрдүүлж байна.


ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
АНУ-ЫН ДОЛЛАР	951.4	928.0
БНХАУ-ЫН ЮАНЬ	521.8	529.1
ОХУ-ЫН РУБЛЬ	213.0	210.2
ЕВРО	87.6	85.4
БНСУ-ЫН ВОН	38.6	38.2
ЯПОНЫ ИЕН	18.9	17.4
БУСАД	10.8	15.8

АШИГТ АЖИЛЛАГАА




НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ТАРХАЛТ

ББСБ–уудын нийт хөрөнгийн өгөөж 6.7 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй адил, өөрийн хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өссөн байна. Нийт ББСБ–ын 23.7 хувь нь 1 хувиас доош өөрийн хөрөнгийн өгөөжтэй, 27.7 хувь нь 1–5 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй, 22.9 хувь нь 5–10 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй, 25.7 хувь нь 10 хувиас дээш өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллалаа. Нийт хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 23.7, 32.3, 26.5, 17.5 хувь байна.



*ROE болон ROA–ийн харгалзах интервал дахь ББСБ–ын тоо /хувиар/




НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХНХ-ИЙН АНГИЛЛААР/

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1.0 тэрбум төгрөгөөс доош ББСБ-уудын тал хувь нь 3.1 хувиас бага, 1–2.5 тэрбум төгрөг ББСБ-уудын тал хувь нь 3.4 хувиас бага, 2.5 тэрбум төгрөгөөс дээш ББСБ-уудын тал хувь нь 5.4 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 3.2, 3.6 болон 7.6 хувьтай байна.

ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

ББСБ-ууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцоход зардал, орлогын харьцаа 63.8 хувь гарсан нь өмнөх онтой харьцуулахад 4.4 пунктээр өсчээ. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 63.8 төгрөгийн зарлага гаргажээ.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- o AFI-аас гаргасан санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох зөвлөмж зааврын дагуу ББСБ-уудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:




ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА

Уг харьцаа 112.8 хувь гарч байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан нь эрсдэлийг мөн хувиар нөхөх чадамжтай болохыг харуулж байна.


Энэ нь өмнөх оны мөн үеэс 5.6 нэгжээр өссөн үзүүлэлт юм.

112.8%




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

Чанаргүй зээлийн хэмжээ 513.9 тэрбум төгрөгт хүрч нийт зээлд эзлэх хувь нь өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн байна.




ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА

Хөрвөх чадвартай хөрөнгийн харьцаа өмнөх оны мөн үеэс 4.0 пунктээр буурсан байна.




Z ИНДЕКС

Z индекс нь ББСБ-ын дампуурах магадлалыг харуулдаг ба нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг нийт хөрөнгийн өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. Банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оны мөн үеэс 3.7 нэгжээр буурсан байна.



Нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлт




СТАНДАРТ ХАЗАЙЛТ

Стандарт хазайлт гэдэг нь өгөгдлүүд дундаж хэмжээнээс хэр зэрэг өөрчлөлттэй байгааг тодохойлдог статистик үзүүлэлт юм. Нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлтыг сүүлийн 4 улирлын өгөөж дээр суурилан тооцдог. Энэхүү стандарт хазайлтын утга их байвал өгөөж хэлбэлзэл ихтэйг харин бага бол өгөөж хэлбэлзэл бага буюу тогтвортой байгааг илэрхийлнэ. Уг утга нь өмнөх оны мөн үеэс 0.0052 нэгжээр өссөн байна.

ФИНТЕК

	Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/
	Хэмжээ /гэрбум төгрөг/	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	
Финтек	1,866.1	28.0%	2,466,888	88.5%	756.5
Уламжлалт	4,808.8	72.0%	321,187	11.5%	14,971.8
НИЙТ	6,674.9	100.0%	2,788,075	100.0%	2,394.1


- ББСБ–ын салбарын нийт харилцагчдын 91.1 хувь нь, нийт зээлдэгчдийн 88.5 хувь нь финтек үйлчилгээнд хамрагджээ.



Жич: Технологид суурилсан болон технологи, уламжлалт хосолсон цаашид "Финтек" гэнэ.



НОГООН ЗЭЭЛ



Ногоон зээлийн үлдэгдэл: 10,993 зээлдэгчид олгосон ногоон зээлийн үлдэгдэл 143.4 тэрбум төгрөг байгаа нь тус салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.1 хувийг эзэлж байна.

	Нийт зээлийн эцсийн үлдэгдэл /сая төгрөг/	Зээлдэгчдийн тоо /эцсийн үлдэгдэл/
Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	123.3	25
Эрчим хүчний үр ашиг	7,757.1	3,026
Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	5,929.1	156
Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	110.8	17
Тогтвортой ус, хог хаягдал	1,538.1	27
Тогтвортой хөдөө аж, ахуй	10,165.2	388
Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	736.2	40
Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	39,949.3	1,456
Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	2,110.4	54
Эрүүл мэнд	9,910.0	220
Боловсрол, Соёл	3,632.4	156
Хүртээмжтэй дэд бүтэц	142.3	3



ХЭВИЙН

89.9%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН


6.2%



ЧАНАРГҮЙ

3.9%

НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ ТЭЭВЭР



- Цахилгаан тээврийн хэрэгсэл
- Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл
- Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл
- Дугуй, скүүтэр
- Бусад

ТАЙЛАНТ УЛИРАЛДС ОЛГОСОН ЗЭЭЛ

Төрөл	Олгосон зээлийн дүн (сая төгрөг)	Зээл олгосон зээлдэгчдийн тоо
1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	473.0	33
2. Эрчим хүчний үр ашиг	12,658.6	5,438
3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	21,484.8	1,289
4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	123.3	23
5. Тогтвортой ус, хог хаягдал	1,781.1	17
6. Тогтвортой хөдөө аж, ахуй	12,696.9	604
7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	1,129.1	46
8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	66,656.8	3,059
9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	1,209.8	54
10. Эрүүл мэнд	9,524.7	238
11. Боловсрол, Соёл	6,944.8	191
12. Хүртээмжтэй дэд бүтэц	8,704.0	1
Нийт	143,386.9	10,993

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг баталсан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д, 78 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журамд ББСБ-аас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа 60 хувиас хэтрэхгүй ба суудлын автомашин барьцаалсан зээл, зээл үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар тусгасан.
- 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тусгай зөвшөөрөлтэй нийт 300 ББСБ-д Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ буюу нэмэлт, өөрчлөлт орсон журмуудын талаар танилцуулах сургалт зохион байгуулсан.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалт:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах үүргийг 92.6 хувь буюу 529 ББСБ, аудитаар баталгаажсан тайланг 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлэх үүргийг 89.1 хувь буюу 509 ББСБ хэрэгжүүлсэн.

“Зээлийн мэдээллийн тухай” хууль:

- Хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 510 ББСБ-ын 97.8 хувь буюу 499 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль:

- Тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу нэр бүхий 98 ББСБ 15,712 удаагийн тохиолдлоор 1,546.4 тэрбум төгрөгийг, 7.2-т заасны дагуу нэр бүхий 9 ББСБ, 259 удаагийн тохиолдлоор 27.9 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлжээ.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”

- Нийт 573 ББСБ-ийн 1,471.5 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 97.7 хувь буюу 559 ББСБ-аас 1,473.4 сая төгрөг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрсөн байна.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

376.9 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **15.0%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

18–64 насны иргэдийн **26**

хүн тутмын 1 нь
ХЗХ–нд гишүүнчлэлтэй

45.0%
дээд боловсролтой



Хүртээмжтэй байдал

Нийт хадгаламжийн

96.7%

Хугацаатай хадгаламж



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

8.1

тэрбум төгрөг

Улсын төсөвт
төвлөрүүлсэн
татвар, НДШ

2.7

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт эзэлд эзлэх чанаргүй
зээлийн хувь

2.4%

Мөнгөн хөрөнгийн нийт
хөрөнгөд эзлэх хувь

14.0%


Бодлого зохицуулалт



ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- Тайлант улиралд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–дын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4–өөр буюу 2.2 хувиар буурч;
- ХЗХ–дын гишүүдийн тоо 3.6 хувиар өсжээ.
- ХЗХ–дын тоо 2021 оны мөн үетэй харьцуулбал 24.4 хувиар буурсан бол гишүүдийн тоо 4.3 хувиар өссөн байна.



АЖИЛЛАГСАД

593

Өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар буурсан ба 72.2 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

НИЙТ ГИШҮҮДИЙН


28,937

ЗЭЭЛДЭГЧ

48,817

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Нийт хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 4.2 пунктээр нэмэгдэж, 2021 оны мөн үетэй харьцуулахад 0.4 пунктээр буурлаа.

НИЙТ ЗЭЭЛ

294.8

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ХАДГАЛАМЖ

259.4

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Салбарын нийт хөрөнгийн

- 90.9 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 43 ХЗХ;
- 4.0 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл хөрөнгөтэй 22 ХЗХ;
- 5.1 хувийг 500 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 112 ХЗХ эзэлж байна.

1.0 тэрбум төгрөгөөс дээш

90.9%

43 ХЗХ

4.0%
22 ХЗХ

500.0 сая төгрөгөөс доош

500.0 саяас 1.0 тэрбум

112 ХЗХ

5.1%

Тайлангийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


Нийт хөрөнгийн дүн	376.9	100.0%
Санхүүгийн хөрөнгө	362.5	96.2%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	52.8	14.0%
Зээл /цэврээр/	303.1	80.4%
Бусад санхүүгийн хөрөнгө	6.6	1.8%
Санхүүгийн бус хөрөнгө	14.4	3.8%
Татварын авлага	0.2	0.1%
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	0.0	0.0%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3.4	0.9%
Бараа материал	0.4	0.1%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1.0	0.2%
Бусад санхүүгийн бус хөрөнгө	2.3	0.6%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /цэврээр/	0.0	0.0%
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.9	1.3%
Биет бус хөрөнгө /цэврээр/	2.2	0.6%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	376.9	100.0%
Санхүүгийн өр төлбөр	290.8	77.2%
Хадгаламж	276.7	73.4%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	4.8	1.3%
Бусад санхүүгийн өр төлбөр	9.3	2.5%
Санхүүгийн бус өр төлбөр	3.8	1.0%
Өөрийн хөрөнгө	82.3	21.8%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	29.7	7.9%
Өмчийн бусад хэсэг	0.4	0.1%
Хоршоологчдын өмч	52.2	13.8%

Тайлбар:

*Сангийн сайдын 2024 оны А/49 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу боловсруулсан болно.

- Нийт хөрөнгийн 96.2 хувь нь санхүүгийн хөрөнгө, үлдсэн 3.8 хувь нь санхүүгийн бус хөрөнгө байна.
- Санхүүгийн хөрөнгийн бүрдлийг нийт хөрөнгөд эзлэх хувиар задалбал 14.0 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 80.4 хувийг цэвр зээл, 1.8 бусад санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд 77.2 хувийг санхүүгийн өр төлбөр, 21.8 хувийг өөрийн хөрөнгө, 1.0 хувийг санхүүгийн бус өр төлбөр бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

39 ХЗХ

8 САЛБАР

ХАНГАЙН БҮС

17 ХЗХ

18 САЛБАР

ТӨВИЙН БҮС

22 ХЗХ

20 САЛБАР

ЗҮҮН БҮС

14 ХЗХ


11 САЛБАР

УЛААНБААТАР

85 ХЗХ

6 САЛБАР

- Улаанбаатар хотод 85 ХЗХ, орон нутагт 92 ХЗХ бүртгэлтэй байна.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 42.4 хувь нь баруун бүсэд, 23.9 хувь нь төвийн бүсэд, 18.5 хувь нь хангайн бүсэд, 15.2 хувь нь зүүн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод ХЗХ-дын 96.5 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 3.5 хувь нь алслагдмал гурван дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байна.




АFI-ийн улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг¹ ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 ААН–д ногдох ХЗХ–дын тоогоор тооцоолоход дараах байдалтай байна.

Монгол Улсын 2024 оны нийт хүн амын урьдчилсан тооцоог ҮСХ–ноос эрхлэн гаргасан *Хүн амын 2015–2045 оны шинэчилсэн хэтийн тооцооны тайлангаас нягтлан үзэж "А" хувилбараар гаргасан хүн амыг сонгож нягтралыг гаргасан болно.

10 000 хүнд ногдох ХЗХ–ны тоо



1 000 ААН–д ногдох ХЗХ–ны тоо



- 1,000 ААН–д ногдох ХЗХ–ны тоогоор Налайх болон Чингэлтэй дүүрэг тэргүүлж харин Баянгол дүүрэг хамгийн доогуур жагсаж байна.
- 10,000 хүнд ногдох ХЗХ–ны тоогоор Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэг тэргүүлж байна.

¹ <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>

* <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/3315830>



Хүртээмжийн үзүүлэлтийг 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор баруун бүс, 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор зүүн бүс тэргүүлж байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 68 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээ хүртжээ.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 62 хүн тутмын нэг бол Улаанбаатар хотын хэмжээнд 77 хүнд тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг гишүүн дунджаар 10.2 сая төгрөгийн зээлтэй.
- Улаанбаатар хотын хэмжээнд уг дүн 17.5 сая төгрөг, орон нутагт 4.6 сая төгрөг байна.


ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 41 хүн тутмын нэг нь ХЗХ-нд хадгаламжаа байршуулсан.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 46 хүнд нэг, Улаанбаатар хотын хэмжээнд 36 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-нд хадгаламж эзэмшигч нэг гишүүн дунджаар 5.3 сая төгрөгийн хадгаламжтай.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.5 сая төгрөг, орон нутагт 2.7 сая төгрөг байна.


Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ




ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ



НАСНЫ БҮЛГЭЭР



БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР



Нийт ажилчдын тоо **593**



Эмэгтэй 428
Эрэгтэй 165



Нийт зээлдэгчдийн тоо **28,937**

Эмэгтэй 16,694
Эрэгтэй 12,118
Хуулийн этгээд 125



Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо **48,817**

Эмэгтэй 26,721

Эрэгтэй 21,995

Хуулийн этгээд 101



Нийт гишүүдийн тоо **76,879**

Эмэгтэй 41,469


Эрэгтэй 35,045

Хуулийн этгээд 365

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ–ДЫН ЗЭЭЛ

- Тайлант улиралд нийт зээл өмнөх оны мөн үеэс 51.5 тэрбум төгрөгөөр өссөн болно.
- 2021 оны мөн үетэй харьцуулбал нийт зээл 108.0 тэрбум төгрөгөөр буюу 57.8 хувиар нэмэгджээ.
- Цэвэр зээлийн хэмжээ 303.1 тэрбум төгрөгт хүрсэн бол, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 5.7 тэрбум төгрөг байна.



ХЭВИЙН

93.0%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

4.6%



ЧАНАРГҮЙ

2.4%

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Хэвийн зээлийн хэмжээ 19.6 хувиар өсөж 274.2 тэрбум төгрөг;
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 89.1 хувиар өсөж 13.6 тэрбум төгрөг боллоо.
- Чанаргүй зээлийн хэмжээ 7.0 тэрбум төгрөгт хүрсэн нь 2021 оны мөн үетэй харьцуулахад 1.0 хувиар өсжээ.

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

- Нийт зээлийн 13.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээнд, 10.5 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд, 9.7 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд тус тус олгосон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 10.9 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээд, 6.7 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд, 5.4 хувь нь барилгын салбарт олгосон зээлээс тус тус төлөгджээ.
- Нийт хаагдсан зээлийн 22.3 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд, 15.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээнд, 9.1 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд зориулж олгосон зээлээс тус тус бүрджээ.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

ХААГДСАН ЗЭЭЛ

Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа



3.0% 9.7% 22.3%

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ



10.9% 13.0% 15.2%

ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур



3.9% 2.0% 1.0%

Санхүүгийн, даатгалын үйл ажиллагаа



6.7% 10.5% 9.1%

Барилга



5.4% 2.8% 1.1%

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа



4.0% 2.0% 0.4%

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ



2.0% 1.0% 0.5%

Боловсруулах үйлдвэр



3.1% 1.9% 0.8%

Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа




0.8% 0.5% 0.2%

Бусад



60.2% 56.6% 49.4%

■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- Тайлант улиралд хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар буюу 33.3 тэрбум төгрөгөөр өссөн.
- 2021 оны мөн үетэй харьцуулбал 68.2 тэрбум төгрөгөөр буюу 35.7 хувиар нэмэгджээ.

НИЙТ ХАДГАЛАМЖ

- Хадгаламж эзэмшигчид ХЗХ-нд 250.8 тэрбум төгрөгийг хугацаатай, 8.6 тэрбум төгрөгийг хугацаагүй байршуулсан байна.



96.7%

ХУГАЦААТАЙ



3.3%

ХУГАЦААГҮЙ



173 ХЗХ



4 ХЗХ

- ХЗХ-дын 97.7 хувь буюу 173 ХЗХ нь 259.4 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 2.3 хувь буюу 4 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ


- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 29 ХЗХ 229.5 тэрбум төгрөг;
- 10 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 133 ХЗХ 29.88 тэрбум төгрөг;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай 11 ХЗХ 0.06 тэрбум төгрөгийн хадгаламжийг тус тус татан төвлөрүүлсэн .
- Огт хадгаламж татан төвлөрүүлээгүй 4 ХЗХ байна.



1.4%

Хугацаатай хадгаламжийн
жигнэсэн дундаж сарын хүү

2.2%

Зээлийн жигнэсэн
дундаж сарын хүү

ОРЛОГО

ХЗХ–дын хүүгийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.4 хувиар өсөж 42.6 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд;

- Зээлийн хүүгийн орлого 38.7 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 3.3 тэрбум төгрөг;
- Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.9 тэрбум төгрөг;
- Зээлийн хүүгийн орлогын буцаалт 0.3 тэрбум төгрөг байна.



ЗАРДАЛ

ХЗХ–дын хүүгийн зардлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.3 хувиар өсөж 22.3 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд:



- Хадгаламжийн хүүгийн зардал 21.9 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагад төлсөн болон бусад хүүгийн зардал 0.4 тэрбум төгрөг;
- Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал 0.04 тэрбум төгрөг;
- Хүүгийн зардлын буцаалт 0.1 тэрбум төгрөг байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ-ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант улиралд ХЗХ-ны салбар 44.5 тэрбум төгрөгийн орлого олж, 36.4 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, 8.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

Хөрөнгийн өгөөжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:


- өөрийн хөрөнгийн өгөөж 3.0 пунктээр;
- нийт хөрөнгийн өгөөж 0.4 тунктээр тус тус өсжээ.




- ХЗХ-д НДШ-д 1.4 тэрбум төгрөг, ААНОАТ-т 0.5 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.8 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт нийт 2.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0.6 пунктээр өслөө.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өсжээ.



■ Үйл ажиллагааны зардал ■ Нийт орлого ○ Үйл ажиллагааны зардал / Нийт орлого



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА

- ХЗХ-д 100.0 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 26.1 төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж байна.




ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARLS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

■ Чанаргүй зээл /тэрбум төгрөг/ ○ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь




ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Тайлант улиралд чанаргүй зээлийн дүн 7.0 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан. ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх шаардлагыг хангаж байна.


ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ

- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.6 пунктээр буурчээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өмнөх оны мөн үеэс 3.5 пунктээр, муу зээл 1.1 пунктээр буурч тус тус өсжээ.




ХЗХ-ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР

- ХЗХ-дын нийт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буурлаа.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа 78.2 хувь байна.



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- ХЗХ-дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан.

Харьцаа	Зохистой хувь	Тайлант улиралд
Бусдаас авсан зээл/Нийт хөрөнгө	<20%	1.6%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	40%–80%	68.8%
(Нийт зээлийн үлдэгдэл – Эрсдэлийн сан)/Нийт хөрөнгө	60%–85%	80.4%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	13.8%
Нөөцийн сан/Нийт хөрөнгө	>3%	32.4%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<10%	3.1%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

o Хадгаламж, зээлийн хоршооны салбарт мөрдөгдөх эрх зүйн орчин

Улсын Их Хурлын даргын 2025 оны 258 дугаар захирамжаар Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Уг хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлал, дагалдах хууль, үр нөлөөний үнэлгээ, ХЗХ-дын 2025 оны I улирлын санхүүгийн тайлангийн хураангуй танилцуулга зэрэг холбогдох баримт бичгийг ажлын хэсгийн гишүүдэд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн.

o Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэн баталгаажуулж ирүүлбэл зохих 171 ХЗХ-ноос 87.1 хувь буюу 149 ХЗХ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

o Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 177 ХЗХ-ны 61.6 хувь буюу 109 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Үүний 52.3 хувь буюу 57 ХЗХ нийслэлд, 47.7 хувь буюу 52 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг болно.

o Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Хуульд заасны дагуу 14 ХЗХ Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-д 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 6,468,037.93 мянган төгрөгийн 137 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

o “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

Журмын хүрээнд зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих 95 ХЗХ-ноос 61 ХЗХ 44,033.0 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Азийн Хөгжлийн Банктай 2022–2025 онд хамтран хэрэгжүүлсэн TA–6883REG: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азид жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийн хүрээнд хадгаламж, зээлийн хоршоодод зориулсан “Хүртээмжтэй ногоон санхүү”, сургагч багш нарт зориулсан “Жендерийн мэдрэмжтэй ногоон санхүү” гарын авлага хэвлүүлсэн.
- CAREC–ийн орнуудын хооронд туршлага судлах цахим уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтад Пакистан, Узбекистан улсын төв банк болон холбогдох яамдын төлөөлөл, Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /ACCU/, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны төлөөлөл оролцож, ХЗХ–дод тулгарч байгаа жендер болон ногоон санхүүгийн асуудлаар туршлага солилцлоо.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28–ны өдрийн А/76 тоот тушаалаар “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж, тайлагнах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдсаны дагуу төрийн байгууллагууд болон ХЗХ–ны төлөөллүүд хамтран хадгаламж, зээлийн хоршооны салбарын эмзэг байдлыг үнэлж байна.



МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

Нийт хөрөнгө

1.1 их наяд төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Улаанбаатар

368

Орон нутаг

181



Хүртээмжтэй байдал



Ашигт ажиллагаа



Нийт орлого
154.0 тэрбум төгрөг

Тайлант үеийн ашиг
79.6 тэрбум төгрөг


Бодлого зохицуулалт




САЛБАРЫН ТӨЛӨВ

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн тоон мэдээлэл

Тайлант улиралд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч 549 байгаагаас 362 нь хуулийн этгээд, 187 нь иргэн болно. Эдгээрээс 71 хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй байна.



Нийт хөрөнгө, нийт зээл /тэрбум төгрөг/



Өмнөх оны мөн үетэй харьцуулбал Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч (МЗҮАЭ):

- Нийт хөрөнгийн хэмжээ 1.4 дахин буюу 336.9 тэрбум төгрөгөөр;
- Нийт зээлийн хэмжээ 641.8 тэрбум төгрөгт хүрч 1.3 дахин буюу 131.7 тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

Хувь нийлүүлсэн хөрөнгө / Нийт хөрөнгө



- Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээр нь авч үзвэл 100 сая хүртэлх төгрөгтэй 431 МЗҮАЭ, 100 саяас 300 сая хүртэлх төгрөгтэй 47 МЗҮАЭ, 300 саяас 1 тэрбум хүртэл төгрөгтэй 56 МЗҮАЭ, 1 тэрбум дээш төгрөгтэй 15 МЗҮАЭ байна.
- Харин нийт хөрөнгийн дүнгээр авч үзвэл 100 сая хүртэлх төгрөгтэй 319 МЗҮАЭ, 100 саяас 300 сая төгрөг хүртэл төгрөгтэй 84 МЗҮАЭ, 300 саяас 1 тэрбум хүртэл төгрөгтэй 62 МЗҮАЭ, 1 тэрбум дээш төгрөгтэй 84 МЗҮАЭ байна.

МЗҮАЭ–дийн активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,071.3	96.7%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	45.8	4.1%
НИЙТ ЗЭЭЛ	641.8	57.9%
ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ	20.7	1.9%
БУСАД ХӨРӨНГӨ	363.1	32.8%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	36.8	3.3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,108.1	100.0%

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийт хөрөнгийн 96.7 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 4.1 хувийг мөнгөн хөрөнгө, 57.9 хувийг нийт зээл, 1.9 хувийг өмчлөх бусад хөрөнгө, 32.8 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна. Харин нийт хөрөнгийн 3.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгө болно.

МЗҮАЭ–дийн пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ӨР ТӨЛБӨР	552.4	49.9%
ЗЭЭЛ	177.0	16.0%
ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	103.7	9.4%
БУСАД ӨР ТӨЛБӨР	271.7	24.5%
ЭЗДИЙН ӨМЧ	555.7	50.1%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	93.0	8.4%
ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ	462.7	41.7%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,108.1	100.0%

Нийт өр төлбөр ба эздийн өмчийн 49.9 хувийг өр төлбөр эзэлж байна. Өр төлбөрийн 16.0 хувийг зээл, 9.4 хувийг гаргасан өрийн бичиг, 24.5 хувийг бусад өр төлбөр бүрдүүлэв.

НИЙТ ЗЭЭЛ



ХЭВИЙН

91.0%



ЧАНАРГҮЙ

9.0%

МЗҮАЭ 362 хуулийн этгээд 635.6 тэрбум төгрөгийг 141,515 зээлд гаргасан байна. Харин МЗҮАЭ 187 иргэн 6.2 тэрбум төгрөгийг 3,976 зээлд олгожээ.

ИРГЭН



0.6%

1.9%

1.9%

ХУУЛИЙН ЭТГЭЭД



99.4%

98.1%

98.1%

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ



ИРГЭН

МЗҮАЭ иргэн дунджаар 1 зээлдэгчид Улсын хэмжээнд 1.6 сая төгрөгийг зээлсэн бол энэхүү үзүүлэлт орон нутагт 0.7 сая төгрөг, Улаанбаатар хотод 3.4 сая төгрөг байна.


ХУУЛИЙН ЭТГЭЭД

МЗҮАЭ хуулийн этгээдээс 1 зээлдэгчид олгосон зээлийн дундаж Улсын хэмжээнд 4.5 сая төгрөг бөгөөд энэ үзүүлэлт орон нутагт 6.0 сая төгрөг, Улаанбаатар хотод 4.3 сая төгрөг байна.




НИЙТ ЗЭЭЛ /тэрбум төгрөгөөр/

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа МЗҮАЭ-ийн зээлийн өрийн үлдэгдэл 559.3 тэрбум төгрөг байгаагаас хуулийн этгээдийн олгосон зээлийн үлдэгдэл 555.0 тэрбум төгрөг, иргэний олгосон зээлийн өрийн үлдэгдэл 4.3 тэрбум төгрөг байна.
- Орон нутгийн хувьд 82.4 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй ба үүнээс хуулийн этгээдээс олгосон зээлийн үлдэгдэл 80.5 тэрбум төгрөг, иргэнээс олгосон зээлийн үлдэгдэл 1.9 тэрбум төгрөг байна.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

12 МЗҮАЭ
5 САЛБАР

ХАНГАЙН БҮС

100 МЗҮАЭ
14 САЛБАР

ТӨВИЙН БҮС

55 МЗҮАЭ
29 САЛБАР

ЗҮҮН БҮС

14 МЗҮАЭ
6 САЛБАР

- 368 МЗҮАЭ Улаанбаатар хотод, 181 МЗҮАЭ орон нутагт бүртгэлтэй байна.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй МЗҮАЭ-дийн 6.6 хувь нь баруун бүсэд, 55.3 хувь нь хангайн бүсэд, 30.4 хувь нь төвийн бүсэд, 7.7 хувь нь зүүн бүсэд байршжээ.
- Бүсээр нь авч үзвэл баруун бүсэд 8 иргэн, 4 хуулийн этгээд, хангайн бүсэд 83 иргэн, 17 хуулийн этгээд, төвийн бүсэд 18 иргэн, 37 хуулийн этгээд, зүүн бүсэд 5 иргэн, 9 хуулийн этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн байна.

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй МЗҮАЭ–дийн 98.9 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 1.1 хувь нь алслагдмал хоёр дүүрэгт байршиж байна.
- МЗҮАЭ–дийн 23.4 хувь нь Баянзүрх, 21.7 хувь нь Баянгол, 19.8 хувь нь Сүхбаатар, 12.0 хувь нь Хан–Уул, 12.0 хувь нь Чингэлтэй, 10.0 хувь нь Сонгинохайрхан, 0.8 хувь нь Налайх, 0.3 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршиж байна.
- Үүнээс 73 нь иргэн, 295 нь хуулийн этгээд байна.



Улсын хэмжээнд 42 МЗҮАЭ–ийн 158 салбар үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 104 нь Улаанбаатар хотод, 54 нь хөдөө орон нутагт байршиж байна.




Үүнээс 101 салбар нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн.

АШИГТ АЖИЛЛАГАА



ЗАРДЛЫН БҮТЭЦ

Нийт зардлын 38.7 хувь нь үйл ажиллагааны, 17.9 хувь нь цалингийн, 7.3 хувь нь орлогын албан татвар, 3.6 хувь нь түрээсийн, 2.4 хувь нь НДШ, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, 30.1 хувь нь бусад зардал тус тус эзэлж байна.



ОРЛОГЫН БҮТЭЦ

Нийт орлогын 95.0 хувь нь зээлийн хүүгийн, 0.3 хувь нь харилцах, хадгаламжийн хүүгийн, 1.3 хувь нь бусад хүүгийн үлдсэн 3.4 хувь нь бусад орлогоос тус тус бүрдэж байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг сурталчлах, мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаарх мэдлэг олгох, барьцаат зээлийн үйлчилгээ авахдаа анхаарах асуудлууд болон зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалтуудыг танин мэдүүлэх зорилгоор “Нарантуул” ОУХТ, “Саруул” зах, “Мөнгөн завьяа” дэлгүүр зэрэг томоохон худалдааны төвийн лангуу түрээслэгчид, нийслэлийн 9 дүүрэгт хүнс, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж, иргэдийн ажлын байран дээрх өглөөний уулзалтыг 2025 оны 05 дугаар сард зохион байгууллаа.
- Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаж байгаа эсэхэд газар дээрх шалгалтыг 2025 оны 06 дугаар сард хийж гүйцэтгэлээ.
- Уг шалгалтаар эрх бүхий байгууллагад бүргүүлэхгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн 17 иргэнийг илрүүлсэн болон Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээг хэтрүүлэн хүү тогтоосон, тус зөвлөлийн 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн гэрээ”, “Барьцааны гэрээ” – ний ерөнхий загварыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрсэн байна. Зөрчил гаргасан нийт 17 иргэн, 2 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 11.34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 3 дахь хэсэгт заасны дагуу нийт 25.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрх бүхий этгээдэд бүртгүүлсний үндсэн дээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг мэдэгдсэн.



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

313.0
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан
даатгагчид ногдох
батлан даалтын
дундаж хэмжээ

31.1
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн
хүсэлтийн тоо

1,376



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Үйл ажиллагааны орлого

15.7 тэрбум төгрөг

Тайлант үеийн цэвэр үр дүн

(0.2) тэрбум төгрөг


Тогтвортой байдал



Чанаргүй батлан
даалтын эзлэх хувь

1.8%


САЛБАРЫН ТӨЛӨВ




Өмнөх оны мөн үетэй харьцуулбал Зээлийн батлан даалтын сан (ЗБДС):

- Нийт хөрөнгийн хэмжээ 4.1 хувиар буюу 12.3 тэрбум төгрөгөөр;
- Батлан даалтын үлдэгдэл 1.8 дахин буюу 197.3 тэрбум төгрөгөөр;
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл 1.8 дахин буюу 344.4 тэрбум төгрөгөөр тус тус өслөө.


Батлан даалт болон батлан даалттай зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Олгосон батлан даалтын тоо




Шинээр олгосон батлан даалтын дүн /тэрбум төгрөг/





Өмнөх оны мөн үеэс олгосон батлан даалтын дүн 74.4 хувиар, тоо 74.7 хувиар тус тус буурсан.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ /тэрбум төгрөгөөр/





НЭГ БАТЛАН ДААЛТЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

- Нэг зээлдэгчийн батлан даалтын үлдэгдэл дунджаар Улаанбаатар хотод 364.1 сая төгрөг, орон нутагт 26.2 сая төгрөг, улсын хэмжээнд 31.1 сая төгрөгт хүрэв.
- Бүс нутгуудын хувьд төвийн бүсэд нэг зээлдэгчид олгосон батлан даалтын дундаж үлдэгдэл хамгийн их буюу 33.3 сая төгрөг байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2022.II	38	23	60.5%
2023.II	132	102	77.3%
2024.II	5,441	5,441	100.0%
2025.II	1,376	1,376	100.0%

ХҮСЭЛТИЙН ТОО

Батлан даалт гаргуулах 1,376 хүсэлт 100.0 хувь шийдвэрлэсэн. Энэ тоо өмнөх оны мөн үеэс 4.0 дахин буурчээ.

Үйл ажиллагааны чиглэлээр

Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа



11.4%

Боловсруулах үйлдвэр



6.8%

Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа



4.2%

Бусад




77.6%

Бусад салбарт олгосон батлан даалтын 71.7 хувийг иргэн, 2.3 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 1.8 хувийг зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 1.4% Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 0.4 хувийг мэдээлэл, холбоо, 0.1 хувийг хоол үйлдвэрлэл, төрөлжсөн бус дэлгүүрийн бусад жижиглэн худалдаа, мал аж ахуй бүрдүүлж байна.

БАТЛАН ДААЛТ БАНКААР

Олгосон батлан даалтын 56.4 хувийг Хаан банк, 18.2 хувийг Төрийн банк, 11.0 хувийг Худалдаа хөгжлийн банк, 6.7 хувийг Голомт банк, 5.1 хувийг Капитрон банк, 2.4 хувийг Хас банк, 0.2 хувийг Ариг банкаас гаргасан зээл бүрдүүлсэн.



БАТЛАН ДААЛТ ЭХ ҮҮСВЭРЭЭР


ЗБДС-аас олгож буй батлан даалтын эх үүсвэрийн 27.3 тэрбум төгрөгийг шинэ хоршоо хөдөлгөөн, 10.2 тэрбум төгрөгийг Азийн Хөгжлийн Банкны МОН-3338, 3.3 тэрбум төгрөгийг ипотека, 1.3 тэрбум төгрөгийг банк, 405.0 сая төгрөгийг атар-4, 150.0 саяг цагаан алт, 58 сая төгрөгийг Жижиг, Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сангийн төсөл тус тус бүрдүүлж байна.

БАТЛАН ДААЛТ ГАРГАСАН ДУНДАЖ ХУГАЦАА

- Гаргасан батлан даалтын дундаж хугацаа 83.3 сар буюу 6.9 жил байна.
- Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 3.1 сараар өссөн үзүүлэлт юм.

83.3
САР


Олгосон батлан даалтын хувь хэмжээ




БАТЛАН ДААЛТТАЙ ЗЭЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Батлан даалттай олгосон зээлийн 68.9 хувийг иргэн, 31.1 хувийг аж ахуйн нэгж бүрдүүлж байна. Аж ахуйн нэгжид олгосон батлан даалтын 12.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа, 6.2 хувийг боловсруулах үйлдвэр, 6.0 хувийг хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар эзэлж байна. Иргэнд олгосон батлан даалтын 67.7 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөн болон 32.3 хувийг ипотека эзэлж байна.

Иргэн /тэрбум төгрөг/



ААН /тэрбум төгрөг/




АШИГТ АЖИЛЛАГАА




Орлогын бүтэц



Зарлагын бүтэц




Нийт хөрөнгийн өгөөж



НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

ЗБДС-ийн нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр буурсан үзүүлэлтэй байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



Чанаргүй батлан даалтын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан ч хэмжээ нь 2.0 тэрбум төгрөгөөр өссөн.

Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилж үзвэл дараах байдалтай:





ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

303



Салбарын төлөв

ҮХЭХЗ-ын
борлуулалтын дүн

1,398.3

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



97.4%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхлэгчид

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ



Тайлант улиралд нийт 303 байгууллага тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8-аар буюу 2.6 хувиар буурсан байна.

Санхүүгийн
зохицуулах хорооны
тусгай зөвшөөрөлтэй

303

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагууд:

Брокер **320**

Агент **1,112**




Нэг ҮХЭХЗ-ын байгууллага дунджаар 1 брокер, 4 агенттай ажиллаж байна. Хамгийн олон агенттай ҮХЭХЗ-ын байгууллагын агентын тоо 86 байна.

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

ҮХЭХЗ-ын байгууллагууд нь 440 хувьцаа эзэмшигчдийн 7.1 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.



Брокерын тоо 320 болж, өмнөх оны мөн үеэс 4-өөр буюу 1.2 хувиар буурсан бол агентын тоо 1,112 болж, өмнөх оны мөн үеэс 228-аар буюу 17 хувиар буурчээ.



НИЙТ ХӨРӨНГӨ

ҮХЭХЗ-ын байгууллагуудын нийт хөрөнгө 225.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 167.5 тэрбум төгрөг буюу 74.3 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 58.0 тэрбум төгрөг буюу 25.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 181.2 тэрбум төгрөг буюу 80.4 хувийг өр төлбөр, 44.3 тэрбум төгрөг буюу 19.6 хувийг эздийн өмч тус эзэлж байна.

ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	Мөнгөн дүн / тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	167.5	74.3%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	58.0	25.7%
ӨР ТӨЛБӨР	181.2	80.4%
ЭЗДИЙН ӨМЧ	44.3	19.6%

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

ҮХЭХЗ-ын байгууллагуудын нийт хөрөнгийн 71.9 хувийг 15 компани, 28.1 хувийг 288 компани бүрдүүлж байна.

Нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг авч үзвэл 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 32 компани 86.4 хувийг, 500 сая төгрөгөөс 1 тэрбум төгрөг хүртэл хөрөнгөтэй 14 компани 4.3 хувийг, 100 сая төгрөгөөс 500 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 66 компани 6.8 хувийг, 100 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 191 компани 2.5 хувийг тус тус бүрдүүлж байна.


ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Хөрөнгийн хэмжээ	Байгууллагын тоо	Зах зээлд эзлэх хувь
100 сая төгрөг хүртэл	191	2.5%
100 сая төгрөг – 500 сая төгрөг хүртэл	66	6.8%
500 сая төгрөг – 1 тэрбум төгрөг хүртэл	14	4.3%
1 тэрбум төгрөг дээш	32	86.4%

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ


ҮХЭХЗ-ын байгууллагуудын 440 хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 7.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ҮХЭХЗ-ын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн бүтцийг авч үзвэл 93.7 хувийг иргэд, 5.0 хувийг хуулийн этгээд, үлдсэн 1.3 хувийг иргэн хуулийн этгээд хамтран эзэмшиж байна.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮХЭХЗБ–УУДЫН БАЙРШИЛ:



2.7%
ОРОН НУТАГ **8**



31.0%
СҮХБААТАР **94**

26.7%
ХАН-УУЛ **81**

10.2%
ЧИНГЭЛТЭЙ **31**

9.9%
БАЯНГОЛ **30**

18.5%
БАЯНЗҮРХ **56**

1.0%
СОНГИНОХАЙРХАН **3**

ҮХЭХЗ–ын байгууллагуудын 31.0 хувь нь Сүхбаатар, 26.7 хувь нь Хан–Уул, 18.5 хувь нь Баянзүрх, 10.2 хувь нь Чингэлтэй, 9.9 хувь нь Баянгол, 1.0 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байгаа бол орон нутагт 8 байгууллага буюу 2.7 хувь байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



ШИГТГЭЭ

Тайлант улиралд нийтийн орон сууцны 1 м.кв-ын дундаж үнэ 3.8 сая төгрөг, тансаг зэрэглэлийн орон сууцны 1 м.кв-ын дундаж үнэ 6.6 сая төгрөг байна.

ҮХЭХЗ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ



Худалдсан, худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн талбайн 82.5 хувийг газар, 14.8 хувийг орон сууц, 1.7 хувийг арилжааны, 1.0 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай ҮХХ тус тус эзэлж байна.

ҮХЭХЗ-ын байгууллагуудын ирүүлсэн мэдээгээр худалдсан үл хөдлөх эд хөрөнгийн үнийн дүнгийн 87.7 хувийг орон сууц, 8.5 хувийг арилжааны зориулалттай, 2.7 хувийг газар, 1.1 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай ҮХХ эзэлж байна.

ҮХЭХЗ-ын байгууллагуудаар дамжуулан худалдан борлуулсан үл хөдлөх эд хөрөнгийн нийт үнийн дүнгийн хэмжээгээр 50-аас доош м.кв нь 20.0 хувийг, 51-ээс 100 м.кв хүртэлх нь 45.1 хувийг, 101-ээс 200 м.кв хүртэлх нь 20.9 хувийг, 201 м.кв-аас дээш талбайтай нь 14.0 хувийг тус тус эзэлж байна.

ҮХЭХЗ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ



Түрээсэлсэн нийт үл хөдлөх эд хөрөнгийн үнийн дүнгийн 64.9 хувийг орон сууцны, 26.3 хувийг арилжааны зориулалттай, 6.2 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, 2.6 хувийг газар эзэлж байна.

Түрээсэлсэн үл хөдлөх эд хөрөнгийн талбайн 53.8 хувийг орон сууц, 40.4 хувийг арилжааны зориулалттай, 5.0 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, 0.8 хувийг газар эзэлж байна.


ҮХЭХЗ-ын байгууллагуудаар дамжуулан түрээсэлсэн үл хөдлөх эд хөрөнгийн нийт үнийн дүнгийн хэмжээгээр 50-аас доош м.кв 17.1 хувь, 51-ээс 100 м.кв хүртэлх 33.5 хувь, 101-ээс 200 м.кв хүртэлх 23.7 хувь, 201 м.кв-аас дээш талбайтай нь 25.8 хувийг тус тус эзэлж байна.

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗ-ын 303 байгууллага тайлант улиралд өссөн дүнгээр 5,466 хэлцлээр, 2,293.7 мянган м.кв талбай, 1,398.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан худалдан шилжүүлжээ.



Үл хөдлөх эд хөрөнгийн худалдаа





○ Талбайн хэмжээ /мянган м.кв/

■ Мөнгөн дүн /тэрбум төгрөг/

2,293.7 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 1,398.3 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 2.7 хувь, үнийн дүн 10.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

АШИГТ АЖИЛЛАГАА



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн реалторуудын холбоо (National association of Realtors)-оос 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотод болсон "Realtors' Legislative Meeting-2025" арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцлоо.
- Монголын үл хөдлөх хөрөнгө удирдлагын академиас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан "Реалторуудын дуу хоолой 2025" арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцлоо.
- ҮХЭХЗ-ын байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад тайлан мэдээ болон Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 31-ны өдөр мөн 06 дугаар сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулсан.
- Санхүүгийн зохицуулах хороо, Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоотой байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр тус холбооны төлөөлөлтэй уулзалт зохион байгууллаа.



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

56

Хуулийн этгээд

492

Иргэн



Салбарын төлөв

Худалдан авсан үнэт
металл

123.8

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



73.2%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэгч


Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ


ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ тусгай зөвшөөрөлтэй 56 хуулийн этгээд, 492 иргэн үйл ажиллагаа эрхэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хуулийн этгээд 5.6 хувиар, үйл ажиллагаа эрхлэх иргэдийн тоо 8.6 хувиар өссөн байна.



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

56



492

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ТОО

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Нэр бүхий 56 хуулийн этгээдийн 88 хувьцаа эзэмшигчдийн 10.2 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.


Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 360 буюу 73.2 хувь нь Улаанбаатар хотод, 132 буюу 26.8 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод


73.2%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АРИЛЖАА ЭРХЛЭГЧИД /БАЙРШЛААР/: УЛААНБААТАР ХОТ




ОРОН НУТАГТ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ИРГЭД ТОО 132:




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДСАН БОЛОН ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛ:

2025 оны 2 дугаар улирлын байдлаар 860.9 кг үнэт металлыг 123.8 тэрбум төгрөгөөр худалдан авч, 506.4 кг үнэт металлыг 140.6 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын үнийн дүн 16.5 хувиар, худалдсан үнэт металлын үнийн дүн 3.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



ҮНЭТ МЕТАЛЛ ЭРХЛЭГЧИД БОЛОН ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ ХООРОНДЫН АРИЛЖАА



ХУДАЛДСАН БОЛОН ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН



**ХУДАЛДАЖ АВСАН
ҮНИЙН ДҮН**

16.6 тэрбум төгрөг

**ХУДАЛДАЖ
БОРЛУУЛСАН
ҮНИЙН ДҮН**

30.7 тэрбум төгрөг

Тайлант улиралд өссөн дүнгээр нийт 16.6 тэрбум төгрөгийн үнэт эдлэл худалдан авч, 30.7 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг борлуулсан байна.

ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	74.3	84.9%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	13.2	15.1%
ӨР ТӨЛБӨР	50.9	58.1%
ЭЗДИЙН ӨМЧ	36.6	41.9%

АШИГТ АЖИЛЛАГАА

Нийт орлого

34.6

Тэрбум төгрөг

Нийт зарлага

29.8

Тэрбум төгрөг

Цэвэр ашиг

4.8

Тэрбум төгрөг

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Монгол дархны уламжлал, шинэчлэл” анхдугаар чуулганыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Санхүүгийн зохицуулах хороо, Түмэн Эрдэнэс” ГҮТББ хамтран 2025 оны 05 дугаар сарын 01–ний өдөр зохион байгууллаа.
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны 05 дугаар сарын 28–ны өдрийн тушаалаар байгуулсан үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний стандартын төсөл хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий Үнэт эдлэлийн стандартчиллын техникийн хороонд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж байна.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны Өвөрхангай аймаг дахь орон нутгийн төлөөлөгчийн хүсэлтээр аймгийн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын талаарх сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 05–ны өдөр зохион байгуулсан ба сургалтад 9 оролцогч хамрагдлаа.



СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Хүсэлтийн тоо **24***
Туршигдаж буй
компани **5**



Салбарын төлөв

A

4
шууд оролцогчид

24.2
тэрбум төгрөгийн
арилжаа



Биржийн бус зах зээлийн
блокчэйн арилжааны систем



1,976

удаагийн хэлцлээр

408.2

тэрбум төгрөгийн арилжаа



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

P2P зээлийн үйлчилгээ



11,359

Харилцагчид

4.0

тэрбум төгрөгийн зээл

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ



3,098

Хөрөнгө
оруулагчид

268.3

сая төгрөгийн санхүүжилт

B2B зээлийн үйлчилгээ



261

Бүртгэлтэй харилцагчид

100.1

тэрбум төгрөгийн зээл

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Сэндбоксад ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 24* хүсэлт ирсэн байна. Сэндбокс зохицуулалтын орчинд репо хэлцлийн үйлчилгээ, хадгаламжийн сертификат, итгэлцлийн үйлчилгээ, P2P зээлийн үйлчилгээ, краудфандинг буюу хамтын санхүүжилтийн үйлчилгээ, биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем болон богино хугацаат санхүүжилтийн зуучлал В2В зээлийн үйлчилгээ гэсэн нийт 5 компанийн 7 бүтээгдэхүүн, үйлчилгээ туршигдаж байна.

8*
Бүтээгдэхүүн сэндбокс орчинд орсон



5
Бүтээгдэхүүн сэндбокс орчинд туршигдаж байна.

В2В зээлийн үйлчилгээ

В2В зээлийн үйлчилгээ нь 2024 оны нэгдүгээр сард сэндбоксын орчинд орсон бөгөөд аж ахуй нэгжүүдийн богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээг хангах, байгууллагуудын харилцах дансанд буй илүүдэл нөөцийг эргэлтэд оруулах замаар зах зээл дэх эх үүсвэрийг үр ашигтайгаар ашиглах боломжийг олгон зээлдэгч, хөрөнгө оруулагчийг холбох үйлчилгээг туршиж байна.



261

Бүртгэлтэй харилцагч

100.1

тэрбум төгрөг
В2В зээлийн олгосон дүн



Тайлант улирал хүртэлх байдлаар В2В зээлийн үйлчилгээний платформд бүртгэлтэй 261 харилцагч байгаа бөгөөд нийт 100.1 тэрбум төгрөгийн зээл тус платформоор олгогдсон байна. Үүнээс 90.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Мөн В2В зээлийн жигнэсэн дундаж хүү 1.5 хувьтай байгаа бол хугацааны хувьд 7, 14, 21, 28, 42 гэсэн хоногуудтай байна.



В2В зээлийн хугацаа

7, 14, 21, 28, 42 хоног



В2В зээлийн дундаж хүү

1.5%

Мөнгөний захын арилжааны платформ

Мөнгөний захын арилжааны платформ нь 2021 оны арван хоёрдугаар сард сэндбокс орчинд орсон бөгөөд банк бус санхүүгийн байгууллагуудын репо хэлцлийн арилжаа, хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, факторинг (хямдруулсан нэхэмжлэл), итгэлцлийн үйлчилгээнд суурилсан мөнгөний захын хэрэгслийг арилжаалах, төлбөр тооцоо, бүртгэл, хадгалалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн туршиж байна.

Хадгаламжийн сертификат

2023 оны есдүгээр сараас эхлэн тайлант улирлыг хүртэлх байдлаар нийт 251.6 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Анхдагч арилжааны дүн Хоёрдогч арилжааны дүн

239.5 сая төгрөг **12.1** сая төгрөг

Итгэлцэл

2023 оны аравдугаар сараас эхлэн тайлант улирлыг хүртэлх байдлаар нийт 7.0 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээг зуучилсан байна.


Анхдагч арилжааны дүн Хоёрдогч арилжааны дүн

6.1 тэрбум төгрөг **919.0** сая төгрөг



Репо хэлцлийн арилжааг эхлүүлснээс хойш тайлант улирлыг хүртэл тус платформ дээр 50 зээлдүүлэгч, 42 зээлдэгч нийт 408.2 тэрбум төгрөгийн 1,976 удаагийн арилжаа хийсэн байна.

Тайлант улиралд репо хэлцлийн арилжаа нь нийт 45 удаагийн 12.4 тэрбум төгрөгийн илүүдэл нийлүүлэлт, 24 удаагийн 6.0 тэрбум төгрөгийн илүүдэл эрэлттэй байсан. Репо зээлийн дундаж хугацаа 37 хоног, дундаж хүү 21.0 хувьтай байна.



Репо зээлийн дундаж хүү

21.0%



Репо зээлийн дундаж хугацаа

37 хоног


7 хоног 14 хоног 28 хоног 84 хоног

Хүснэгт . Репо хэлцлийн ерөнхий үзүүлэлтүүд

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
2023.II	17	19	117	24,250,000,000	17.2	31
2024.II	19	25	158	41,300,000,000	17.7	33
2025.II	26	29	272	57,640,000,000	21.0	37

Репо хэлцлийн үзүүлэлтээс харахад, тайлант улиралд зээлийн дундаж хүү болон зээлийн хугацаа өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлдүүлэгч болон зээлдэгчдийн тоо өсөн, арилжааны тоо 158-аас 272, арилжааны дүн 41.3 тэрбум төгрөгөөс 57.6 тэрбум төгрөг болж нэмэгдсэн байна. Түүнчлэн арилжааны дундаж хугацаа 2023 онд 31 хоног байсан бол 2024 онд 33 хоног, 2025 онд 37 хоног болж, тогтмол уртасч байгаа нь урт хугацаат зээлийн эрэлт нэмэгдэж байгааг харуулж байна.

Зураг. Репо хэлцлийн хүүгийн түвшин ба арилжааны дүн /сая төгрөгөөр/, хугацаагаар



Репо зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 2 дугаар улиралд 21.0% болж өссөн байна. Нийт репо хэлцлийн 37.5 хувийг 4 долоо хоногийн хугацаатай, 32.0 хувийг 12 долоо хоногийн хугацаатай, 24.1 хувийг 2 долоо хоногийн хугацаатай, 6.4 хувийг 1 долоо хоногийн хугацаатай репо зээлүүд тус тус эзэлж байна.

P2P зээлийн үйлчилгээ

P2P зээлийн үйлчилгээ нь 2022 оны арван хоёрдугаар сард сэндбокс зохицуулалтын орчинд орсон бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээг хөгжүүлэн туршиж байна.



P2P зээлийн үйлчилгээний харилцагчдын тоо



98.4%
зээлдэгч



1.6%

хөрөнгө оруулагч

Тайлант улирлыг хүртэлх байдлаар тус платформоор 11,359 харилцагчдад P2P зээлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Эдгээр харилцагчдын 1.6 хувь нь хөрөнгө оруулагч бол үлдсэн 98.4 хувь нь зээлдэгч байна.

P2P зээлийн үйлчилгээний платформоор нийт 4.0 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 3.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, P2P үйлчилгээний нийт зээлийн үлдэгдэл 667.8 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд олгосон нийт зээлийн 74.0 хувийг 3 сараас бага хугацаатай зээл, 26.0 хувийг 3 сараас дээш хугацаатай зээл зээлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 29.0 хувийг 1 жилийн хугацаатай, 71.0 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.



1-12 сарын
хугацаатай

Олгосон
зээлийн дүн

4.0 тэрбум төгрөг

667.8
сая төгрөг
Зээлийн үлдэгдэл

ЗЖДХ 2.0%





Хэвийн
98.8%



Хугацаа хэтэрсэн
0.5%



Чанаргүй
0.7%

P2P платфoрmoор зуучлагдан олгогдсон нийт зээлийн 98.8 хувь нь хэвийн, 0.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 0.7 хувь нь чанаргүй зээл байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.0% –тай байна.

Эмэгтэй



65%

Эрэгтэй



35%

Тайлант улирлын байдлаар P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 65.0 хувь нь эмэгтэй, 35.0 хувь нь эрэгтэй харилцагчид байна. Харин нийт харилцагчдын 49.0 хувийг 18–35 насныхан, 35.0 хувийг 36–45 насныхан, 13.0 хувийг 46–55 насныхан, 3.0 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 62.4 хувь нь дээд, 4.0 хувь нь тусгай дунд, 29.1 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь дунд, 0.3 хувь нь бага боловсролтой байна.

НАСНЫ БҮЛГЭЭР

18–35 НАС



49.0%

36–45 НАС



35.0%

46–55 НАС



13.0%

55–ААС ДЭЭШ



3.0%

БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР



62.4%

ДЭЭД



4.0%

ТУСГАЙ
ДУНД



29.1%

БҮРЭН
ДУНД



4.2%

ДУНД



0.3%

БАГА

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь 2022 оны арван хоёрдугаар сард сэндрбоксын орчинд орсон ба урамшуулал, хувьцаа, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг туршиж байна.



Төслийн дундаж хугацаа 21 хоног



Тайлант улирлыг хүртэл нийт хамтын санхүүжилтийн 2.4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 64 төсөл нийтлэгдэн, 4,746 хөрөнгө оруулагчаас нийт 359.4 сая төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлсэн байна.

Үүнээс урамшуулалд суурилсан 39 төслийн 268.3 сая төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Төслүүдийн хувьд дунджаар нийт шаардлагатай санхүүжилтийн 28.0 хувийг босгосон байна.

- Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн 23 төсөл нийтлэгдсэн бөгөөд нийт 1,645 оролцогчоос 55.1 сая төгрөгийн хандивыг босгосон байна.
- Зээлд суурилсан зээлийн 1 төсөл хэрэгжиж 2 хөрөнгө оруулагчаас 11 сая төгрөгийн санхүүжилт босгосон байна.
- Хувьцаанд суурилсан 1 төсөл хэрэгжиж компанийн 2.5 хувийг 25 сая төгрөгөөр санал болгон санхүүжилт босгосон байна.

23 хандивын санхүүжилт



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД НАСНЫ БҮЛГЭЭ

18–35 НАС



62.1%

36–45 НАС



23.9%

46–55 НАС



8.4%

55–ААС ДЭЭШ



5.6%

Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 62.1 хувь нь 18–35 нас, 23.9 хувь нь 36–45 нас, 8.4 хувь нь 46–55 нас, 5.6 хувь нь 55–аас дээш насныхан байна.

Блокчэйн арилжааны систем

Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем нь 2023 оны арван нэгдүгээр сард сэндбоксын орчинд орсон бөгөөд үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, 24/7 гүйцэтгэх блокчэйн системийг нэвтрүүлэн туршиж байна.


Блокчэйн системийн арилжааны ерөнхий мэдээлэл



Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем дээр нийт 237,763 ширхэг үнэт цаас 24.2 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан байна. Мөн бондын жигнэсэн дундаж хүү 22.0 хувьтай бөгөөд тайлант улиралд блокчэйн системд 4 шууд оролцогч оролцжээ.

Блокчэйн системийн арилжааны эзлэх хувь

Биржийн бус зах зээл дээр нийт 1,798.6 тэрбум төгрөгийн хоёрдогч зах зээлийн арилжаа хийгдсэнээс 1.0 хувь буюу 24.2 тэрбум төгрөг нь блокчэйн систем дээр арилжаалагдсан байна.



● Хоёрдогч зах зээлийн арилжаа

● Хоёрдогч зах зээлийн блокчэйн дахь арилжаа



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Зохицуулалтын орчныг сайжруулах ажлын хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 124/75/А/86 дугаар хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-д нэмэлт өөрчлөлт орууллаа. Журмын нэмэлт, өөрчлөлтөөр сэндбоксын орчинд амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулалттай зах зээлд шилжүүлэх үйл явц болон зохицуулалтын орчин бүрдэх хүртэлх хугацааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх талаарх түр зохицуулалт болон сэндбоксын хугацаанд оролцогч үйл ажиллагаагаа түр зогсоох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн тусгай зөвшөөрлийн шаардлагаас зайлсхийх зорилгоор сэндбокс зохицуулалтын орчныг ашиглахыг хязгаарлах зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Сэндбоксын орчныг олон нийтэд таниулах ажлын хүрээнд:

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн уулзалтад оролцон сэндбокс зохицуулалтын орчны туршлагаа хуваалцан, бүс нутгийн сэндбокс нэвтрүүлэхэд анхаарах асуудлуудын талаар хэлэлцлээ.

Монгол Улс, Солонгос Улсын санхүүгийн хамтын ажиллагааны форумд “Санхүүгийн инновац” панел хэлэлцүүлгийн модератораар ажиллан, сэндбокс зохицуулалтын орчны туршлага, санхүүгийн инновацын бодлого, зохицуулалтад үүсэж буй бэрхшээл болон хоёр улсын хамтын ажиллагааны боломжийн талаар хэлэлцлээ.

Сэндбоксын орчны оролцогчдод хяналт тавих, хамтран ажиллах ажлын хүрээнд:

Тайлант улирлыг хүртэлх байдлаар Сэндбокс орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 33 компанитай 91 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг мөн гүйцэтгэн ажиллаж байна.

Финтекийн хөгжил болон зохицуулалтын орчны талаарх цахим болон танхимын сургалт, уулзалтуудад тогтмол оролцож байна.



Сэндбоксод туршигдаж буй 5 бүтээгдэхүүн тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягыг боловсруулан 7 хоног, сар, улирлын тайлан, мэдээг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Сэндбоксод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Виртуал хөрөнгийн
үйлчилгээ үзүүлэгч

12



Салбарын төлөв

Харилцагчийн тоо

694,209



Хүртээмжтэй байдал

Дотоодын виртуал
хөрөнгийн өдрийн
дундаж арилжаа

224.7 сая төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

3.9 тэрбум төгрөг


Алдагдал

3.7 тэрбум төгрөг

Бодлого зохицуулалт




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



ВХҮҮ-д бүртгэлтэй харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 21.4% хувиар буурсан . Үүнээс 73.6 хувь буюу 510,924 нь баталгаажуулалт хийсэн ба эдгээрийн 2.2 хувь буюу 15,239 нь арилжаанд идэвхтэй оролцдог.

БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД



Баталгаажуулалт хийсэн харилцагчдыг ангилан харвал эрэгтэй 53.0 хувь, эмэгтэй 47.0 хувь байна.


Насны бүлгээр авч үзвэл 16-30 насны 37.6 хувь, 31-45 насны 45.9 хувь, 46-с дээш насны 16.5 хувь болно

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН АРИЛЖАА

ВХҮҮ дээр нийт 647.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн.


- Гадаадын виртуал хөрөнгийн арилжаа өмнөх оны мөн үеэс 180.1 тэрбум төгрөгөөр буурсан;
- Дотоодын виртуал хөрөнгийн арилжаа өмнөх оны мөн үеэс 4.4 тэрбум төгрөгөөр өссөн.



- Гадаадын виртуал хөрөнгийн арилжааны дүн /тэрбум төгрөг/
- Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн /тэрбум төгрөг/


ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА

ВХҮҮ дээр өдрийн дундаж арилжаа гадаадын виртуал хөрөнгө 3.4 тэрбум төгрөг, дотоодын виртуал хөрөнгө 0.2 тэрбум төгрөг байна.




АРИЛЖААЛАГДАЖ БУЙ ДОТООД БОЛОН ГАДААД ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ТОО

ВХҮҮ дээр нийт 603 нэр бүхий виртуал хөрөнгө арилжаалагдсанаас 6.1 хувь буюу 37 нь дотоодын, 93.9 хувь буюу 566 нь гадаадын виртуал хөрөнгө болно.



Дотоодын виртуал хөрөнгө өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар буурсан.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

БАЙРШИЛ

Улсын хэмжээнд 12 ВХҮҮ үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 11 нь Улаанбаатар хотод, 1 нь Өмнөговь аймагт байршиж байна.

Улаанбаатар хотод байршиж буй ВХҮҮ-дийн 72.7 хувь нь Сүхбаатар, 18.2 хувь нь Хан-Уул, 9.1 хувь нь Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

НИЙТ ХӨРӨНГӨ

Нийт хөрөнгө 60.1 тэрбум төгрөг бөгөөд үүний 42.3 тэрбум төгрөг буюу 70.5 хувь нь эргэлтийн хөрөнгө, 17.8 тэрбум төгрөг буюу 29.5 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.

Нийт өр төлбөрийн 68.1 хувь буюу 40.9 тэрбум төгрөг нь өр төлбөр, 31.9 хувь буюу 19.2 тэрбум төгрөг нь эздийн өмч эзэлж байна.

Үзүүлэлт	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/	Хөрөнгө болон өр төлбөрт эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгө	42.3	70.5%
Эргэлтийн бус хөрөнгө	17.8	29.5%
Өр төлбөр	40.9	68.1%
Эздийн өмч	19.2	31.9%

3.9

Тэрбум төгрөг
ОРЛОГО

Өмнөх оны мөн үеэс
1.4 дахин буурлаа.

7.6

Тэрбум төгрөг
ЗАРДАЛ

Өмнөх оны мөн үеэс
1.3 дахин өсжээ.

3.7

Тэрбум төгрөг
АЛДАГДАЛ

Өмнөх оны мөн үеэс 7.4
дахин өссөн байна.

Орлого өмнөх оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр буурсан.


Зарлага өмнөх оны мөн үеэс 1.9 тэрбум төгрөгөөр өссөн .

Тус салбарын алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3.2 тэрбум төгрөгөөр өсжээ





ХАВСРАЛТ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2023.ИИ	2024.ИИ	2025.ИИ
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	10,998.6	11,305.7	12,157.3
Зах зээлийн үнэлгээ / ДНБ	20.8%	16.0%	15.2%
Хөрвөх чадвар	1.0%	1.4%	0.9%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	429.8	185.9	111.5
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	37.4	565.0	88.2
ХБҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	42.2	61.6	168.2
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	29.6	38.2	77.9
Засгийн газрын үнэт цаас /тэрбум төгрөг/	–	–	58.1
ТОП–20 индекс	36,899.16	44,385.18	49,246.17
MSE А индекс	16,216.23	17,223.73	17,825.99
MSE Б индекс	12,178.61	13,387.44	14,403.63
ХК–ийн тоо	321	311	311
ҮЦК–ийн тоо	52	52	53
ХААБ–ийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	494.9	657.4	204.1
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүн / тэрбум төгрөг/	1,223.5	6,155.3	1,397.6

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2023.И	2024.И	2025.И
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	518.3	616.6	703.7
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	172.4	226.1	250.6
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	53.4	70.0	88.2
Нөөц сан /тэрбум төгрөг/	244.2	290.6	337.5*
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	44.6	57.0	50.2
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	1.1	19.8	30.1
Мэргэжлийн оролцогчид:			
Ердийн даатгал	15	16	17
Урт хугацааны даатгал	2	2	2
Давхар даатгал	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2,381	2,490	1,093
Даатгалын зуучлагч	64	62	62
Хохирол үнэлэгч	25	26	29
Актуарч	40	40	40
Аудитор	145	147	155
Аудитын компани	44	45	48

* 2025 оны 1 дүгээр улирлаас хойш давхар даатгалын нөөц санг тооцохдоо орлогод тооцсон хураамжийн нөөцийг нэмэгдүүлсэн болно.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023.ИИ	2024.ИИ	2025.ИИ
Нийт хөрөнгө	3,945.9	5,756.6	7,983.4
Эргэлтийн хөрөнгө	3,815.1	5,490.5	7,616.0
Мөнгөн хөрөнгө	524.6	706.7	664.2
Богино хугацаат хөрөнгө оруулалт	34.9	77.0	97.0
Нийт зээл	3,107.5	4,590.5	6,674.9
Хэвийн зээл	2,766.9	4,169.7	5,828.6
Хугацаа хэтэрсэн зээл	103.1	137.9	332.4
Чанаргүй зээл	237.4	282.8	513.9
Зээлийн эрсдэлийн сан	177.5	212.4	357.5
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	21.4	29.6	42.8
Эргэлтийн бус хөрөнгө	130.7	266.1	367.4
Нийт өр төлбөр	1,477.7	2,581.9	3,758.0
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	449.3	884.8	1,175.3
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	428.2	871.9	1,419.5
Төслийн зээлийн санхүүжилт	33.3	19.5	129.7
Эзэмшигчдийн өмч	2,468.1	3,174.7	4,225.3
Хоёрдогч өглөг	75.9	66.2	86.9
Хувьцаат капитал	1,440.0	1,682.2	1,980.5
Хуримтлагдсан ашиг	889.3	1,329.2	2,010.7
ББСБ-ын тоо	522	549	573
Үүнээс: УБ хот	427	450	478
Хөдөө, орон нутаг	95	99	95
Харилцагчдын тоо	3,895,987	4,875,687	3,611,895
Нийт орлого	520.2	800.9	1,264.9
Хүүгийн орлого	439.1	712.9	1,129.2
Хүүгийн бус орлого	68.4	72.1	107.1
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12.6	15.9	28.3
Нийт зардал	331.1	475.8	807.2
Хүүгийн зардал	60.7	167.7	298.0
Хүүгийн бус зардал	189.2	201.3	265.1
Болзошгүй эрсдэлийн зардал	50.7	46.2	147.6
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4.9	60.6	96.5
Цэвэр ашиг	189.1	325.1	457.7

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2023.И	2024.И	2025.И
Нийт хөрөнгө	295.9	327.8	376.9
Эргэлтийн хөрөнгө	291.8	318.6	362.5
Мөнгөн хөрөнгө	52.2	65.8	52.8
Авлага	16.7	17.9	20.7
Эргэлтийн бус хөрөнгө	4.1	9.2	14.4
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.0	4.3	4.9
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.1	2.2
Нийт зээл	220.4	243.3	294.8
Хэвийн зээл	205.1	229.3	274.2
Хугацаа хэтэрсэн зээл	8.0	7.2	13.6
Чанаргүй зээл	7.3	6.8	7.0
Өр төлбөр	234.3	254.6	290.8
Нийт хадгаламж	203.9	226.1	259.4
Богино болон урт хугацаат өр төлбөр	13.9	7.8	4.8
Өөрийн хөрөнгө	61.6	73.2	82.3
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	27.2	28.6	29.7
Хоршоологчдын өмч	34.2	44.3	52.2
Хуримтлагдсан орлого /алдагдал/	12.0	19.0	22.2
Нийт орлого	30.3	36.0	44.5
Хүүгийн орлого	28.7	33.7	42.6
Үйл ажиллагааны бус орлого	1.1	0.9	0.7
Үйл ажиллагааны бусад орлого	0.5	1.4	1.2
Нийт зарлага	27.5	30.2	36.4
Хүүгийн зардал	17.4	19.3	22.3
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	1.5	0.9	1.6
Үйл ажиллагааны зардал	8.1	9.3	11.6
Үйл ажиллагааны бус зардал	0.1	0.0	0.1
Цэвэр орлого	2.8	5.8	8.1
ХЗХ–дын тоо	192	181	177
УБ ХЗХ–дын тоо	101	92	85
Орон нутаг ХЗХ–дын тоо	91	89	92
Гишүүдийн тоо	71,184	74,186	76,879

Тайлбар: Сангийн сайдын 2024 оны А/49 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу боловсруулсан болно.

*Бусад санхүүгийн хөрөнгө, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага болон зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын нийлбэрээр тооцов.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023.И	2024.И	2025.И
Нийт хөрөнгө	257.6	300.7	313.0
Батлан даалтын үлдэгдэл	85.5	250.9	448.2
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	2.6	1.1	6.0
Чанаргүй	9.4	6.0	8.0
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	166.8	455.2	799.6
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	4.7	1.7	11.7
Чанаргүй	20.1	18.1	16.7
Үндсэн үйл ажиллагааны орлого	5.7	10.0	15.7
Үндсэн үйл ажиллагааны зардал	1.4	5.4	15.9
Тайлант үеийн цэвэр үр дүн	4.3	4.6	(0.2)
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	132	5,441	1,376
Олгосон батлан даалтын тоо	97	5,429	1,376
Олгосон батлан даалтын дүн	21.4	167.3	42.8
Үүнээс: Хөдөө аж ахуй	0.3	1.2	0.6
Үйлдвэрлэл	8.7	5.9	2.9
Бөөний болон жижиглэн худалдаа	9.5	14.0	4.9
Иргэн	0.6	134.1	30.7
Бусад	2.3	12.1	3.7
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	164.2	80.2	83.3

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2023.И	2024.И	2025.И
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	311	311	303
Брокерын тоо	324	324	320
Агентын тоо	1,269	1,340	1,112
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн талбайн хэмжээ /мянган м.кв/	707.6	864.6	2,293.7
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн үнэ /тэрбум төгрөг/	992.0	1,268.2	1,398.3
Түрээслүүлж, түрээсэлсэн, Үл хөдлөх эд хөрөнгийн талбайн хэмжээ /мянган м.кв/	232.1	314.2	313.3
Түрээслүүлж, түрээсэлсэн, Үл хөдлөх эд хөрөнгийн үнэ /тэрбум төгрөг/	66.3	103.2	125.6

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2023.И	2024.И	2025.И
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	49	53	56
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн тоо	461	453	492
Худалдан авсан үнэт металлын бохир жин /грамм/	236.8	928.2	860.9
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ / тэрбум төгрөг/	41.3	148.2	123.8
Худалдсан үнэт металлын бохир жин /грамм/	259.6	651.4	506.3
Худалдсан үнэт металлын нийт үнэ /тэрбум төгрөг/	49.0	146.2	140.6
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ / тэрбум төгрөг/	3.8	11.7	16.6
Худалдсан эдлэлийн нийт үнэ / тэрбум төгрөг/	4.1	20.1	30.7

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2024.И	2025.И
ВХҮҮ-ийн тоо	12	12
Харилцагчийн тоо	883,658	694,209
Үүнээс: Идэвхтэй арилжаа хийдэг	24,736	15,239
Баталгаажуулалт хийсэн	435,520	510,924
Дотоодын виртуал хөрөнгийн тоо	45	37
Дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	161.5	145.7
Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн	36.1	40.5
ХНХ	24.9	24.9
Нийт хөрөнгө	65.9	60.1
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	(0.5)	(3.7)

